




БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН

Монгол Улсын Засгийн Газар болон Мянганы Сорилтын Корпорац хооронд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр байгуулагдсан Компакт гэрээний дагуу Монголын Мянганы Сорилтын Сангийн удирдан зарцуулж буй Мянганы Сорилтын Корпорацийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн Аудит

Аудитын хамрах хугацаа: Сонголтот хугацаа #1 буюу 2021 оны 4 дүгээр сарын 1-нээс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр



ММСС-ийн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн**ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

БҮЛЭГ	ХУУДАС
Тайлан хүлээлгэн өгөх захидал	5
1. Хөтөлбөрийн тухай Ерөнхий мэдээлэл Төслийн зорилго, зорилтууд Аудитын хамрах хугацаа Компакт хэрэгжүүлэх хугацааны санхүүгийн төлөвлөгөөний хураангуй ба гүйцэтгэл Гол оролцогч талууд Шууд бус зардал Хуваарилагдсан өртгийн тайлан (Засгийн Газрын оруулах хувь хэмжээ) Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах	6
2. Аудитын зорилго ба хамрах хүрээ Аудитын зорилго Аудитын хамрах хүрээ Аудитын хөтөлбөрүүд Цар хүрээний хязгаарлалт ЗГ-ын Аудитын Стандартын үл тохирол	11
3. Аудитын үр дүнгийн хураангуй БТТГГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 сарын 1-ны өдрөөс 2021 оны 10 сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны СХТ, КГУС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 сарын 1-ны өдрөөс 2022 оны 3 сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны СХТ, КГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 сарын 1-ны өдрөөс 2022 оны 3 сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны СХТ-тай холбоотой аудитаар илэрсэн асуудал ММСС-ийн Санхүүгийн Тайлагналын Дотоод Хяналтын талаар аудитаар илэрсэн асуудал ММСС-ийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн нийцлийн талаар аудитаар илэрсэн асуудал Аудитын үр дүнгийн талаар удирдлагын үзэл бодол	15
4. Аудиторын тайлангууд, нэмэлт тодруулга Нэгтгэсэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн аудиторын тайлан Нэгтгэсэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан (2021 оны 4 сарын 1-ны өдрөөс 2022 оны 3 сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны) БТТГГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 сарын 1-ны өдрөөс 2021 оны 10 сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан КГУС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 сарын 1-ны өдрөөс 2022 оны 3 сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан КГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 сарын 1-ны өдрөөс 2022 оны 3 сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан Нэгтгэсэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн нэмэлт тодруулга Санхүүгийн Тайлагналын дотоод хяналт, нийцэл, бусад асуудлын талаар хараат бус аудиторын тайлан	17
5. Эргэлзээтэй зардал, аудитаар илэрсэн асуудлын бүртгэл Эргэлзээтэй зардал, аудитаар илэрсэн асуудлууд Дотоод хяналтын талаар илэрсэн асуудлууд Гэрээ, хууль тогтоомжийн нийцлийн талаар илэрсэн асуудлууд	34
6. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах	52

Саналын эрхтэй гишүүд

Б. Батцэцэг	Дарга, Гадаад харилцааны Сайд
Э. Баттулга	Гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга
С. Магнайсүрэн	Гишүүн, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга
Ж. Ганбат	Гишүүн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Б. Насантогтох	Гишүүн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга
Д. Ганболд	Гишүүн, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга
Н. Батсүх	Гишүүн, ШУТИС-ийн Геологи, Уул уурхайн сургууль, Геологи, гидрогеологийн салбарын зөвлөх профессор
Б.Цолмон	Зориг сангийн Гүйцэтгэх захирал
О.Амартүвшин	МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч

Саналын эрхгүй гишүүд

Тина Юү	Гишүүн, МСК-ын Монгол дахь Суурин Төлөөлөгч
Д.Энхжаргал	Гишүүн, ММСС-ийн Гүйцэтгэх захирал (интерим)

ММСС-ийн Удирдлагын багийн бүрэлдэхүүн

Д.Энхжаргал	Гүйцэтгэх захирал (интерим)
Д.Хулан	Үйл ажиллагаа хариуцсан захирал
Т.Энхтунгалаг	Хөтөлбөр хариуцсан дэд захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Отгонбаяр	Хуулийн ерөнхий зөвлөхийн үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Батбаяр	Дотоод аудитын захирал
Б.Батсүх	Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн захирал
Т.Хишигт	Хаягдал ус дахин боловсруулах төслийн захирал
Л.Өнөржаргал	Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн захирал
Б.Ууганбаяр	Мониторинг үнэлгээний захирал
А.Отгончимэг	Нийгэм, жендерийн оролцоог хангах асуудал хариуцсан захирал
Г.Уранчимэг	Санхүүгийн захирал Захиргааны асуудал хариуцсан захирал (сонгон шалгаруулах процесс явагдаж байна)
С.Должин	Худалдан авах ажиллагааны захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ц.Дашзэвэг	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний захирал
Б.Амарсанаа	Олон нийттэй харилцах асуудал хариуцсан захирал

Товчилсон үгийн жагсаалт

АМНБИ	Америкийн Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
Ам.доллар	Америк доллар
БТТГГ	Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн гэрээ
БТТГГС	Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн гэрээний санхүүжилт
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДБТ	Дотоод Бизнесийн Төв
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗГ	Засгийн газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ММСС	Монголын Мянганы Сорилтын Сан
МСК	Мянганы Сорилтын Корпораци
ММНБИ	Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт
МУХАУТ	Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим
ОСНААУГ	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
КГУС	Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт
КГС	Компакт гэрээний санхүүжилт
СХТ	Санхүүжилтийн хариуцлагын тайлан
СТДХ	Санхүүгийн тайлагналын дотоод хяналт
СЕГ	Статистикийн Ерөнхий Газар
ТҮХ	Тендерийн Үнэлгээний Хороо
ТЦБ	Төв цэвэрлэх байгууламж
ТНС	Төлбөрийн нэгдсэн систем
ХХБ	Худалдаа Хөгжлийн Банк
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
УСУГ	Ус сувгийн удирдах газар
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ҮАА	Үндэсний ажлын алба



БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: +976-70005401, 70005402
Факс: +976-70005403
E-mail: info@btdalaivanaudit.mn
Web site: www.btdalaivanaudit.mn

ММСС-ийн Удирдах Зөвлөлд
Монголын Мянган Сорилтын Сан
Монгол улс, Улаанбаатар хот
UNESCO-ийн гудамж, Сүхбаатар дүүрэг
MPM Complex-ийн 5 дугаар давхар

Тайлан хүлээлгэн өгөх захидал

Утга: МСК болон МУЗГ-ын хооронд байгуулагдсан Мянган Сорилтын Компакт Гэрээний дагуу ММСС-ийн удирдан зарцуулж буй МСК-ын санхүүжилтийн эх үүсвэрийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн аудит

Аудитын хамрах хугацаа: 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

Бид ММСС-ийн удирдан зарцуулж буй МСК-ын санхүүжилтийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн аудитын тайланг танилцуулж байна. Энэхүү тайланг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК болон ММСС-ийн хооронд 2021 оны 4 дүгээр сарын 1-нд байгуулсан гэрээнд тусгагдсан ажлын даалгаврын дагуу бэлтгэв.

Тайлант хугацаанд нийт 29,953,525.67 ам.долларын зардал гарсан.

Энэхүү аудитын тайланд дараах тайлангуудыг багтаасан:

- Нэгтгэсэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн талаар хараат бус аудиторын тайлан (БТТГГС, КГУС, КГС-ийн эх үүсвэрүүд)
- Санхүүгийн тайлагналын дотоод хяналт, нийцэл, бусад асуудлын талаар хараат бус аудиторын тайлан

Бид ММСС-д Удирдлагын захидал хүргүүлсэн ба уг захидалд дотоод хяналтын материаллаг бус дутагдагдал болон материаллаг бус үл нийцлийн илэрсэн асуудлуудыг тусгасан.

Ц.Жигдэн
Аудит Партнер
Бэйкер Тилли Далайван Аудит ХХК

2022 оны 9 дүгээр сарын 12

1. ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

1.1 Ерөнхий мэдээлэл

МУ-ын ГХЯ-аар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар (“Засгийн газар”) болон МСК-аар Чтөлөөлүүлэн АНУ-ын хооронд (а) 2017 оны 5 дугаар сарын 3-ны өдөр байгуулж, 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан Мянганы Сорилтын Компакт Гэрээнд бэлтгэх, дэмжлэг үзүүлэхэд зориулж 12,025,150 хүртэлх дүн бүхий ам.долларын Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн гэрээ (“БТТГГ”), (б) 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр 350,000,000 хүртэлх дүн бүхий ам.долларын Мянган Сорилтын Компакт Гэрээ (“Компакт гэрээ”) тус тус байгуулагдсан. Компакт гэрээнд бэлтгэх, дэмжлэг үзүүлэхэд зориулах 12,025,150 ам.долларын БТТГГ нь (i) МСК-ийн удирдан зарцуулах 8,500,000 ам.долларын санхүүжилт болон (ii) МУЗГ-ын удирдан зарцуулах 3,525,150 ам.долларын санхүүжилтээс бүрдэнэ.

Компакт гэрээний дүн 350,000,000 ам.доллар нь (i) Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэхэд зориулж Засгийн газарт олгох 321,940,000 хүртэлх дүн бүхий ам.долларын МСК-ын Буцалтгүй тусламж (“Хөтөлбөрийн санхүүжилт”) болон (ii) Компакт гэрээний хэрэгжилтийн бэлтгэлийг хангах хүрээнд Мянганы сорилтын тухай 2003 оны хуулийн 609(g) дэх заалтын дагуу Засгийн газарт олгох 28,060,000 хүртэлх дүн бүхий ам.долларын Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт (“КГУС”)-ээс бүрдэнэ. Эдгээр талууд Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ (“ХХГ”)-г 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан. Компакт гэрээ нь 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүчин төгөлдөр болсон. МСК-аас хөтөлбөрийн санхүүжилтийг Компакт гэрээний хүчин төгөлдөр болсон хугацаанаас хойш 5 жилийн хугацаанд хангана. Компакт гэрээнд заасан нөхцлийн дагуу Засгийн газар 111,760,000 ам.доллар эсвэл тус гэрээнд заасны дагуу бууруулсан дүн бүхий хэмжээний хөрөнгийг Компакт гэрээгээр хэрэгжүүлэх төслийн зорилтыг биелүүлэхэд зориулж Компакт гэрээ хэрэгжих хугацааны туршид хариуцна.

Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 297 тоот тогтоолоор ММСС-г “Улсын төсөвт үйлдвэрийн газар” ангиллаар үүсгэн байгуулсан. ММСС нь төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүү нөөцийг захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах зэрэг Компакт гэрээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүнийг удирдан чиглүүлэх, хяналт тавихтай холбоотой бүхий л эрх, үүргийг хэрэгжүүлэх эрхтэй Засгийн газрын үндсэн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зорилготой. ММСС нь (а) ММСС-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрх бүхий Удирдах Зөвлөл, (б) Хөтөлбөрийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг бүхий Удирдлагын багаас бүрдэнэ. ММСС нь Компакт гэрээ болон бусад холбогдох гэрээний хүрээнд худалдан авах ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ эдгээр чиглэлээр мэргэшсэн Санхүүгийн төлөөлөгч болон Худалдан авах ажиллагааны төлөөлөгчтэй тус тус хамтран ажилладаг.

1.2 Төслийн зорилго, зорилтууд

Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл нь Улаанбаатар хотын унд, ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын тооцоолж буй усны эрэлтийг хангах зорилготой. Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд төслийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн стратегийн ач холбогдол бүхий дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- (i) **Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа**
Улаанбаатар хотын баруун доод хэсэгт орших Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн шинэ эх үүсвэр байгуулна. Энэхүү үйл ажиллагаанд зориулсан МСК-ын санхүүжилтийг дараах ажлыг гүйцэтгэхэд зарцуулна. Үүнд: (i) хоёр шинэ эх үүсвэрт нийт 52 гүний худаг байгуулах, (ii) шахуурга, эх үүсвэр дотор ус цуглуулах шугам хоолой, тохируулгын усан сан болон усыг эх үүсвэрийн талбайгаас ус дамжуулах шугам хоолойг суурилуулах, (iii) усны бохирдлыг (газрын доорх усанд агуулагдаж болзошгүй патоген эмгэг үүсгэгч, дэгдэмхий органик нэгдэл, хүнд метал, бусад бохирдуулагч бодисыг олон шатлалаар цэвэршүүлэх) гүн цэвэршүүлэх дэвшилтэт технологи бүхий байгууламжийг Улаанбаатар хотын баруун доод хэсэгт байгуулах, (iv) нөөцийн сан, шахуургын станц, усыг гүн цэвэршүүлэх байгууламжаас Улаанбаатар хотын одоогийн ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд дамжуулахад шаардлагатай шугам хоолойг татах зэрэг багтана.

(ii) Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаа

Төв цэвэрлэх байгууламж (ТЦБ)-аас гарах их хэмжээний цэвэрлэсэн хаягдал усыг дахин боловсруулж, ашиглана. Энэхүү үйл ажиллагаанд зориулсан МСК-ын санхүүжилтийг дараах ажлыг гүйцэтгэхэд зарцуулна. Үүнд: (i) ТЦБ-аас гарах цэвэршүүлсэн бохир усны тодорхой хэсгийг дахин боловсруулах үйлдвэрийг ТЦБ-ийн хажууд байрлах нийтийн эзэмшлийн талбайд байгуулах, (ii) дахин боловсруулсан усыг гурав болон дөрөвдүгээр Дулааны цахилгаан станц (ДЦС) (тус тус “ДЦС-3,” “ДЦС-4” гэх)-ын дэргэдэх усны нөөцийн сав руу дамжуулах шугам хоолой, шахуургын станц байгуулах, (iii) ДЦС-3 болон ДЦС-4-ийн зарим үйл ажиллагаанд дахин боловсруулсан усыг ашиглахад шаардлагатай хяналтын систем, дотоод шугам хоолой, нөөцийн савыг байгуулах барилга угсралтын ажил багтана.

(iii) Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа

Бодлого, зохицуулалт, хууль эрх зүйн орчин, институцийн асуудлыг хамарсан дараах таван арга хэмжээнээс бүрдэх бөгөөд Улаанбаатар хотын ус хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг сайжруулахад чиглэгдэнэ.

а) Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд техникийн туслалцаа үзүүлэх бөгөөд ингэхдээ ус хангамжийн сайжруулсан үйлчилгээнд УСУГ-ын хэрэглэгчдийн төлөх төлбөрийн чадвар, төлбөр төлөх эрмэлзлийг нарийвчлан үнэлж, уг үнэлгээнд тулгуурлан цэвэр, бохир усны тарифын бүтцийг нарийвчлан судална. Түүнчлэн, энэхүү дэд үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, элэгдэл хорогдлын зардлыг бүрэн нөхөх чадварыг бий болгох тарифын хувилбаруудыг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулахад УСУГ-т туслалцаа үзүүлнэ.

б) Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагаа

Улаанбаатар хотын гэр хороололд ус түгээх байраар дамжуулан ус хангамжийн үйлчилгээг хүргэхэд УСУГ-аас зарцуулж буй өндөр зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ дэд үйл ажиллагааны хүрээнд ус хангамжийн үйлчилгээг хүргэх, борлуулахтай холбоотой гардаг шууд зардлыг бууруулах зорилго бүхий, цар хүрээний хувьд харьцангуй бага ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд: Ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулж, цагийг уртасгах үүднээс энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат ажиллагаанд шилжүүлэх, зөөврийн ус хангамж бүхий ус түгээх байруудыг байнгын/төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд холбох зорилгоор ус хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, УСУГ-ын зөөврийн ус хангамжийн машины ус түгээхэд зарцуулдаг хугацаа, туулдаг зайг багасгах зорилгоор ачилтын худаг нэмж барих зэрэг ажлууд багтана. Түүнчлэн, нийслэлийн хэмжээнд ус хангамжийн дэд бүтцийг өргөжүүлж, хөгжүүлэх асуудлаар УСУГ болон нийслэл, дүүргийн харьяа байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоо, төлөвлөлт, уялдаа холбоог сайжруулахад туслалцаа үзүүлнэ.

в) Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагаа

Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, харьцуулалт хийхэд зориулж Олон улсын усны нийгэмлэгээс боловсруулсан олон улсын “AquaRating” үнэлгээний аргачлалыг ашиглан УСУГ-ын үйл ажиллагааны чадавхийг тодорхой чиглэлүүдээр сайжруулах зорилготой. Энэ хүрээнд, УСУГ-ыг үйл ажиллагааны хувьд ижил төстэй, нийтлэг бэрхшээл бүхий, хөгжингүй орны, өндөр туршлагатай ус ашиглалтын байгууллагатай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтооход шаардлагатай санхүүгийн туслалцааг үзүүлнэ. Түүнчлэн, УСУГ-ын хөрөнгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэхийн зэрэгцээ (тухайлбал, төлөвлөх, захиран зарцуулах, ашиглалттай холбоотой засвар үйлчилгээг гүйцэтгэх зэрэг) хэрэглэгчдийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, үр дүнг оновчтойгоор ашиглах чадварыг сайжруулахад чиглэсэн тодорхой тусламжийг үзүүлнэ.

г) Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд үйл ажиллагаа

Шинэ төв цэвэрлэх байгууламж баригдаж, ашиглалтад орохоос урьтаж нийслэлийн хаягдал ус татан зайлуулах систем дэх үйлдвэрийн бохирдлын түвшинг бууруулах хүчин чармайлтыг дэмжих зорилготой. Үүнд, үйлдвэрийн хаягдал усны эх үүсвэрийг тодорхойлох, түүнд шаардлагатай загварчлалыг боловсруулах, хаягдал усны стандартыг сайжруулах, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, бохирдлыг хянах дүрэм журмыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зэрэг арга

хэмжээ багтана. Түүнчлэн, энэхүү дэд үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд усны бохирдолд хяналт тавих, илрүүлэх, ус бохирдуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Засгийн газрын болон нийслэлийн харьяа байгууллагуудад техникийн туслалцаа үзүүлж, лабораторийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангана.

- д) **Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагаа**
Улаанбаатар хотод нүүрлэж буй усны нөөцийн хомсдолын талаар болон байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрх ашигт нийцсэн байдлаар ус олборлох, ашиглахтай холбоотой бодит өртгийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор холбогдох талууд, олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.3 Төслийн мониторинг

Компакт гэрээний хэрэгжилтэд системтэй мониторинг хийж, Индикаторыг Хянах Хүснэгт (ИХХ)-ийг бэлтгэж тус гэрээний хэрэгжилтийн явцыг тайлагнадаг. Дараах хүснэгтэд ИХХ-ээс “бүтээгдэхүүн” гэсэн индикаторын мэдээллийг багтаан харуулсан.

Үйл ажиллагаа	Дугаар	Индикатор үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Компактын эцэст хүрэх зорилт	Хугацааны эцэст дууссан	Суурь үзүүлэлт	Компактын 1-р жилийн зорилт	Компактын 1-р жилийн гүйцэтгэл
Үйл ажиллагаа 1: Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах	DWA P-04	Ус үйлдвэрлэх хүчин чадал нэмэгдэх	Нэг өдрийн сая литр	50.00		0.00	0.00	
Үйл ажиллагаа 1: Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах	DWA P-01	Дэвшилтэт ус цэвэршүүлэх үйлдвэрийг бүрэн дуусгах	Дууссан өдөр (огноо)	03/30/2026	Хүлээгдэж байна			
Үйл ажиллагаа 1: Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах*	WRA P-04	Баригдсан, сэргээн засварласан эсвэл өргөтгөсөн төвлөрсөн ус, бохир ус цэвэрлэх байгууламжийн доторх цэвэрлэх технологийн нэгжүүд	Тоо			0.00		
Үйл ажиллагаа 1: Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах	DWA P-04	Ус үйлдвэрлэх хүчин чадал нэмэгдэх (гүний усны худгууд)	Жилийн сая шоо метр	50.00		0.00	0.00	
Үйл ажиллагаа 2: (ii) Хаягдал усыг дахин боловсруулах	WSP P-02	Ус үйлдвэрлэх хүчин чадал нэмэгдэх (ус дахин боловсруулах үйлдвэр)	Жилийн сая шоо метр	14.60		0.00	0.00	
Дэд үйл ажиллагаа 3.1: Зардал нөхөхөд чиглэсэн **		Төлбөр төлөх хүсэл эрмэлзлийн судалгааг дуусгах	Дууссан өдөр (огноо)	03/31/2021	Дууссан		03/31/2021	Дууссан
Дэд үйл ажиллагаа 3.1: Зардал нөхөхөд чиглэсэн	WSACR P-11	Үнийн боломжит байдал болон харилцагчдад туслалцаа үзүүлэх судалгааг дуусгах	Дууссан өдөр (огноо)	03/31/2022	Хүлээгдэж байна		03/31/2022	Хүлээгдэж байна
Дэд үйл ажиллагаа 3.1: Зардал нөхөхөд чиглэсэн	WSACR P-02	Тарифын сонголтын судалгааг дуусгах	Дууссан өдөр (огноо)	03/31/2021	Хүлээгдэж байна		03/31/2021	Хүлээгдэж байна
Дэд үйл ажиллагаа 3.3: Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих ***	WSAUC P-05	Түншлэгч партнерууд болон УСУГ хоорондын уулзалт аялал	Тоо			0.00		

* Төвлөрсөн ус эсвэл бохир ус цэвэрлэх байгууламжийн дотор цэвэрлэх технологийн нэгжийг барих ажил эхлээгүй байна. ММСС 2021 оны 8 дугаар сарын 2-нд MAPA INSAAT Ve TICARET AS компанитай "Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, хяналт удирдлагын СКАДА системийн барилга усралтын ажил"-ын гэрээг зурсан. Тус гэрээг 2021 оны 8 дугаар сарын 18-нд эхлүүлж, барилгын ажлыг 2022 оны 5 дугаар сард эхлүүлэхээр тооцсон. Тайлагнах дата мэдээлэл байхгүй.

* Төвлөрсөн ус эсвэл бохир ус цэвэрлэх байгууламжийн дотор цэвэрлэх технологийн нэгжийг барих ажил эхлээгүй байна. Барилгын ажлыг 2022 оны 5 дугаар сард эхлүүлэхээр тооцсон. Тайлагнах дата мэдээлэл байхгүй.

** ММСС-ийн Жендер, Нийгмийн Орлоцооны баг 2021 оны 12 дугаар сарын 17-нд эцсийн тайланг зөвшөөрөх захирыг гаргаж, тус тайланг 2022 оны 1 дүгээр сарын 7-нд Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвөлд хүргүүлсэн.

***Усны Операторуудын Түншлэл/Ихэрлэх Сургалт-ыг хүсэх үйл явц эхлээгүй байна. Түншлэлийн хүсэлтийн талаарх зарлалыг 2021 оны 4 дүгээр улиралд гаргасан ба түншлэлийг 2022 оны 3 дугаар улиралд эхлүүлэхээр тооцсон. Тайлагнах дата мэдээлэл байхгүй.

1.4 Аудитын хамрах хугацаа

Аудитад БТТГГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан, КГУС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дугаар сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан, КГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дугаар сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайланг тус тус хамруулсан.

2021 оны 10 дугаар сард БТТГГС-ийн эх үүсвэр аливаа нэг санхүүжилтийн үлдэгдэлгүй хаагдсан. Иймд БТТГГС-ийн эх үүсвэрийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайланг 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр бэлтгэсэн.

Компакт гэрээ нь 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүчин төгөлдөр болж, тус гэрээний эхний зарцуулалт 2021 оны 5 дугаар сард гарсан.

1.5 Компакт хэрэгжүүлэх хугацааны Санхүүгийн Төлөвлөгөөний Хураангуй болон түүний гүйцэтгэл

Компакт хэрэгжүүлэх хугацааны Санхүүгийн Төлөвлөгөө (КХХСТ)-ний Хураангуй - Компакт гэрээнд тусгасан (сая ам.доллар)

Бүрэлдэхүүн	КГУС	Компакт хэрэгжүүлэх хугацаа					Хөтөлбөрийн нийт зардал	МУЗГ-ын санхүүжүүлэх дүн	МСК-ын санхүүжүүлэх дүн
		1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил			
Ус хангамж нэмэгдүүлэх төсөл									
Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах	16.00	18.65	26.01	81.60	82.62	73.88	298.76	59.26	239.50
Хаягдал усыг дахин боловсруулах	2.25	12.33	20.04	27.70	23.04	10.34	95.70	52.50	43.20
Усны салбарын тогтвортой байдлыг хангах	2.96	5.18	4.41	4.57	1.98	0.90	20.00	0.00	20.00
Дэд дүн	21.21	36.16	50.46	113.87	107.64	85.12	414.46	111.76	302.70
Мониторинг, Үнэлгээ									
Мониторинг ба Үнэлгээний зардал	0.03	0.35	3.45	1.79	1.12	3.62	10.36	0.00	10.36
Дэд дүн	0.03	0.35	3.45	1.79	1.12	3.62	10.36	0.00	10.36
Хөтөлбөрийн удирдлага									
Хэрэгжүүлэгч байгууллагын зардал	6.55	3.28	3.34	3.49	3.54	4.93	25.13	0.00	25.13
Агентын зардал	0.03	2.00	2.00	2.00	2.00	2.67	10.70	0.00	10.70
Аудитын зардал	0.24	0.16	0.17	0.17	0.18	0.19	1.11	0.00	1.11
Дэд дүн	6.82	5.44	5.51	5.66	5.72	7.79	36.94	0.00	36.94
НИЙТ САНХҮҮЖИЛТ	28.06	41.95	59.42	121.32	114.48	96.53	461.76	111.76	350.00

Батлагдсан Санхүүгийн Төлөвлөгөө (КХХСТ)-ний Хураангуй болон зарцуулалтын гүйцэтгэл (сая ам.доллар)

Бүрэлдэхүүн	КГУС-КХХСТ	Нийт зарцуулалт	Үлдэгдэл КХХСТ	Зарц гүйц %	Компактын 1-р жил - КХХСТ	Нийт зарцуулалт	Үлдэгдэл КХХСТ	Зарц гүйц %
Ус хангамж нэмэгдүүлэх төсөл								
Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах	19.98	18.26	1.72	91.39	255.73	21.53	234.20	8.42
Хаягдал усыг дахин боловсруулах	0.03	0.03	0.00	100.00	13.94	2.67	11.27	19.15
Усны салбарын тогтвортой байдлыг хангах	0.81	0.52	0.29	64.20	19.20	0.00	19.20	*0.00
Дэд дүн	20.82	18.81	2.01	90.35	288.87	24.20	264.67	8.38
Мониторинг, Үнэлгээ								
Мониторинг ба Үнэлгээний зардал	0.00	0.00	0.00	0.00	10.33	0.00	10.33	0.00
Дэд дүн	0.00	0.00	0.00	0.00	10.33	0.00	10.33	0.00
Хөтөлбөрийн удирдлага								
Хэрэгжүүлэгч байгууллагын зардал	5.88	5.53	0.35	94.05	12.90	0.58	12.32	4.50
Санхүүгийн удирдлага	0.72	0.72	0.00	100.00	4.06	0.62	3.44	15.27
Худалдан авах ажиллагааны удирдлага	0.54	0.54	0.00	100.00	5.13	0.74	4.39	14.42
Аудитын зардал	0.10	0.10	0.00	100.00	0.65	0.00	0.65	0.00
Дэд дүн	7.24	6.89	0.35	95.17	22.74	1.94	20.80	8.53
НИЙТ САНХҮҮЖИЛТ	28.06	25.70	2.36	91.59	321.94	26.14	295.80	8.12

*2022 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар нийт 349.2 ам.долларын зарцуулалт гарсныг сая ам.доллараар тоймлон харуулсан.

1.6 Гол оролцогч байгууллагууд

Хөтөлбөрийн гол оролцогч байгууллагууд нь:

- Мянганы сорилтын корпорац
- Санхүүгийн төлөөлөгчийн үйлчилгээ үзүүлэгч Cardno Emerging Markets USA, Ltd
- Худалдан авах ажиллагааны үйлчилгээ үзүүлэгч Charles Kendall and Partners Ltd
- Гадаад харилцааны яам
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Эрчим хүчний яам
- Барилга, хот байгуулалтын яам
- Сангийн яам
- Улаанбаатар хотын захирагчийн алба
- Төв цэвэршүүлэх байгууламж
- Дулааны цахилгаан станц 3

- Дулааны цахилгаан станц 4
- Ус сувгийн удирдах газар
- Үндэсний статистикийн хороо
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
- Худалдаа Хөгжлийн Банк

1.7 Шууд бус зардал

МСК-аас шууд бус зардал санхүүжүүлэх талаар Компакт гэрээ болон бусад гэрээнд заагаагүй учраас шууд бус зардалтай холбоотой аудитын горимыг хэрэгжүүлэх шаардлагагүй байсан.

1.8 Хуваарилагдсан өртгийн тайлан (Засгийн Газрын оруулах хувь хэмжээ)

Компакт гэрээний дагуу МУЗГ-аас Компакт гэрээний хэрэгжих хугацаанд хариуцсан санхүүжилтээ хийнэ. Аудитын хамрах хугацаанд засгийн газрын санхүүжилт хараахан эхлээгүй байсан учраас тайлант хугацаанд ММСС хуваарилагдсан өртгийн тайлан бэлтгэх шаардлагагүй байсан.

1.9 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах

Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж, хэрэгжилтийн байдлыг харуулав.

Аудитын зөвлөмж	Хэрэгжилтийн байдал
Дотоод хяналтын тогтолцоог илүү оновчтой ба системтэй бүрдүүлэхийн тулд Америкийн Засгийн Газрын Хариуцлагын Албанаас гаргасан Дотоод хяналтын стандартад заасан зарчмуудыг хангаж буй эсэхийг удирдлагын зүгээс үнэлж үзэх нь зүйтэй.	Бүрэн хэрэгжсэн (хаагдсан)
ММСС холбоотой талуудыг тодорхойлох, холбоотой талын ажил гүйлгээг нэмэлт тодруулгад тусгах талаар бодлого процедурыг тодорхойлж, Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөөний баримт бичигт тусгах хэрэгтэй.	Шаардлагагүй болсон (хаагдсан)
Санхүүгийн төлөөлөгч нь гамшгаас сэргийлэх төлөвлөгөөг хамгийн багадаа жилд нэг удаа тестлэн шалгаж, үр дүнг баримтжуулах хэрэгтэй.	Бүрэн хэрэгжсэн (хаагдсан)
Ажлын нөхцөл болон ангиллыг стандартын дагуу ММСС-ийн албан тушаал тус бүрийн ажиллах нөхцөлийг үнэлж, тодорхойлсны дараа хөдөлмөрийн гэрээний загварт албан тушаал бүрийн хөдөлмөрийн нөхцөлийн зүйл, заалтыг нэмэх шаардлагатай.	Хэсэгчлэн хэрэгжсэн (давтагдсан)
Хөдөлмөрийн тухай хууль болон Хүний нөөцийн гарын авлагад нийцүүлэн илүү цагаар ажиллахтай холбоотой заалтыг хөдөлмөрийн гэрээнд нэмж оруулах нь зүйтэй.	Хэсэгчлэн хэрэгжсэн (давтагдсан)
Хүний нөөцийн гарын авлагад заасан "... мэдэгдэх хугацааны оронд нэг (1) сарын цалинтай тэнцэх олговор олгох" гэсэн бүх хэсгийг устгах хэрэгтэй.	Хэсэгчлэн хэрэгжсэн (давтагдсан)

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Аудитын зорилго нь Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн гэрээ болон Компакт гэрээний дагуу ММСС-ийн удирдан зарцуулж буй МСК-ын санхүүжилтийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд АНУ-ын Нягтлан бодох бүртгэлийн Ерөнхий газраас гаргасан АНУ-ын ЗГ-ын аудитын стандарт болон МСК-ын эрх бүхий этгээдээс гэрээлсэн санхүүгийн аудитад баримтлах зааварчилгаа-ны дагуу аудитыг хийж гүйцэтгэхэд оршино.

МСК-аас эх үүсвэртэй санхүүжилтэд аудит хийхдээ дараах тусгайлсан зорилтуудыг хангана:

- МСК-ын санхүүжилтээр хэрэгжиж буй хөтөлбөрийн аудитад хамрах хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд тусгагдсан хүлээн авсан санхүүжилтийн орлого, гарсан зардал, МСК болон Засгийн газар (ММСС болон Бусад аудитад хамрагдах нийлүүлэгчид)-аас шууд худалдан авсан хөрөнгө болон техникийн туслалцаа нь материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх, холбогдох гэрээ болон нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим буюу нягтлан бодох бүртгэлийн бусад иж бүрэн суурь (мөнгөн орлого ба зарцуулалтын суурь болон тохируулсан мөнгөн суурийг багтаасан)-т нийцсэн эсэх талаар дүгнэлт гаргана.
- МСК-ын санхүүжилтээр хэрэгжиж буй хөтөлбөртэй уялдуулан ММСС-ийн дотоод хяналтыг үнэлэх, хяналтын эрсдэл, мөн дотоод хяналтын зохион байгуулалт, үр нөлөөтэй байдалтай холбоотой ноцтой дутагдал болон материаллаг сул талыг тодорхойлох. Энэхүү үнэлгээнд хуваарилагдсан өртгийн санхүүжилтийн тайлантай холбоотой дотоод хяналт багтана.
- ММСС-ийн үйл ажиллагаа нь Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн гэрээ болон Компакт гэрээ (Засгийн Газарт хуваарилагдсан өртөгтэй холбоотой МСК-ын журам зааврыг багтаан), Нэмэлт гэрээнүүд, МСК-ын санхүүжилтэд хамаарах хууль тогтоомж, хэрэгжүүлэгч байгууллага болон нийлүүлэгчийн гэрээний мөрдөлтөнд материаллаг үл нийцэл байгаа эсэхийг аудитын сорил хийж тодорхойлох. Бодитой тохиолдсон эсвэл тохиолдох боломжтой материаллаг үл нийцэл болон хууль бус үйлдлийг тогтооно. Хэрэгжүүлэх аудитын сорилд хуваарилагдсан өртгийн санхүүжилттэй холбоотой нийцлийн шаардлагыг оруулна. Аудитын хамрах хугацаанд тусгайлан худалдан санхүүжилт хүлээн авагч байгууллагатай холбоотой МСК-ын Хөтөлбөрийн Худалдан авах ажиллагааны зааварчилгаа, ЗГ-ын байгууллагуудын дагаж мөрдөх МСК-ын Зардлын зарчмууд, ММСС-ийн Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөө, МСК-ын санхүүжилттэй тусламж, хэрэгжүүлэгч байгууллагын эсвэл нийлүүлэгчийн гэрээний нөхцөл, шаардлагын хүрээнд материаллаг үл нийцэл байсан эсэхийг тодорхойлох аудитын сорилыг хийж гүйцэтгэнэ.
- ММСС нь өмнөх хугацааны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар хариу арга хэмжээ авсан эсэхийг тодорхойлно.

2.2 Аудитын хамрах хүрээ

Аудитаар БТТГГС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан, КГУС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан, КГС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд дүгнэлт өгөх, ММСС-ийн дотоод хяналт, холбогдох хууль тогтоомжийн нийцлийн тайлан гаргах ажлууд багтсан.

Аудитын өмнөх үе шатанд хийгдсэн ажил

Бид дараах баримт бичгүүдийг авч танилцсан:

1. Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн гэрээ, Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн гэрээ, Компакт гэрээ, Компакт гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой МСК, ЗГ болон ММСС-ийн хийсэн, эдгээр хооронд байгуулсан нэмэлт гэрээнүүд

2. Бусад баримт бичгүүд: а) Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ, б) Банкны гэрээ, в) Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн гэрээ, г) Санхүүгийн төлөөлөгчийн гэрээ, д) Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө, е) Худалдан авах ажиллагааны гарын авлага, ё) Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ж) Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа, з) Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ, и) Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө, к) Хэрэгжилтийн төлөвлөгөө, л) Аудитын төлөвлөгөө болон м) Төсөл эсвэл төслийн үйл ажиллагааны ажлын төлөвлөгөө
3. ММСС болон ММСС-ийн өмнөөс МСК эсвэл ЗГ-ын санхүүжилттэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх нийлүүлэгчид, тусламж хүртэгчид ба бусад байгууллагуудын хооронд хийгдсэн гэрээ
4. ММСС болон бусад хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд хийсэн дэд гэрээ эсвэл хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ
5. Нийлүүлэгчийн гэрээ болон гуравдагч талуудтай хийсэн дэд гэрээ
6. МСК болон ММСС-ийн баталсан төсөв, хэрэгжилтийн албан бичиг болон журмууд
7. Хөтөлбөрийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, дансны нэгдсэн жагсаалт, байгууллагын бүтэц зохион байгуулалт, нягтлан бодох бүртгэлийн систем, бодлого, худалдан авах ажиллагааны бодлого, журмууд, ажил гүйцэтгэхэд шаардлагатай материал хүлээн авах, хадгалах, хуваарилах журам
8. Аудитын хамрах хугацаанд хүчин төгөлдөр ашиглагдаж буй ЗГ-ын байгууллагуудын дагаж мөрдөх МСК-ын Зардлын зарчмууд
9. Аудитын зорилготой шууд холбоотой өмнөх хугацааны аудит, санхүүгийн хяналтын үр дүн.

Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан

Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан нь аудитын хамрах хугацааны туршид ММСС-ийн МСК болон ЗГ-аас хүлээн авсан санхүүжилтийн орлого, мөн хугацаанд ММСС-ийн гаргасан зардал, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, ММСС-ийн хэрэгцээнд зориулж МСК эсвэл ЗГ-ын санхүүжилтээр худалдан авсан хөрөнгө болон техникийн тусалцааг толилуулах зорилготой санхүүгийн тайлан юм.

Бид БТТГГС, КГУС болон КГС-ийн эх үүсвэр бүхий МСК-ын санхүүжилтээр ММСС-ийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд аудит хийсэн. ЗГ-ын санхүүжилт Компактын 2-р жилд эхлэх учраас бидний аудит хийсэн тайланд ЗГ-т хуваарилагдсан өртгийн зарцуулалт багтаагүй. Аудит эхлэхээс өмнө ММСС-ийн удирдлага эдгээр тайлангийн үнэн зөв байдлыг хариуцахаа илэрхийлсэн.

Төлбөрийн Нэгдсэн Систем (ТНС)

Төлбөрийн Нэгдсэн Систем (ТНС)-ийн бодлого журмын дагуу хийгдсэн эсэхийг тодорхойлохын тулд ТНС-ээр хийгдсэн төлбөрийн бичилт болон төлбөрийн дэлгэрэнгүй тайланд аудит хийсэн. Мөн төлбөрийн хүсэлт Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөөнд заасан эрх бүхий албан тушаалтнаар батлагдсан эсэх, төлбөр нь бэлтгэн нийлүүлэгчдийн нэхэмжлэх болон төлбөрийн дэлгэрэнгүй тайлантай нийцэж буй эсэхийг нягтлах зорилгоор түүврээр сонгон авсан төлбөрийн хүсэлтийн маягтуудыг шалгасан. Мөн төлбөрийн дэлгэрэнгүй тайлангийн дүнг ММСС-ийн нягтлан бодох бүртгэл руу тулгаж, МСК-аас төлбөр хийгдсэн хугацааг үнэлсэн.

Дотоод хяналтын бүтэц

Хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой ММСС-ийн дотоод хяналтын бодлого, үйл явцын зохион байгуулалтын талаар хангалттай мэдээлэл олж авах, тэдгээр бодлого, үйл явц нь бодитоор хэрэгжиж буй эсэх, Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлохын тулд ММСС-ийн дотоод хяналтын бүтцийг шалгасан. ММСС-ийн дотоод хяналтын талаар ойлгож, үнэлэх аудитын шаардлагыг хангах үүднээс бид АМНБИ-ийн SAS No. 122 (AU-C sec 315) *Байгууллага, түүний орчныг ойлгох, материаллаг буруу тайлагналын эрсдэлийг үнэлэх стандарт*, SAS No. 122 (AU-C sec 265) *Аудитаар илэрсэн дотоод хяналттай холбоотой асуудлыг танилцуулах* стандартыг тус тус мөрдлөг болгосон.

ММСС-ийн дотоод хяналтыг шалгахад дараах горимуудыг хэрэгжүүлсэн.

- а. Аудитын төлөвлөлтийн шатанд дотоод хяналтын талаар ойлголт олж авах, аудитаар хэрэгжүүлэх горим сорилын шинж чанар, хугацаа болон цар хүрээг тодорхойлох.
- б. Уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлэх, нэгдсэн эрсдэлийг тодорхойлох.
- в. Аудитын төлөвлөлтийн шатанд аудитын батламж мэдэгдэлд хамаарах эрсдэлийн үнэлгээ

хийх.

г. Дотоод хяналтын орчин, нягтлан бодох бүртгэлийн систем болон хяналтын үйл явцын зохистой байдлыг үнэлэх.

Дотоод хяналтын бүтцийн үнэлгээ нь дараах зорилгуудыг агуулсан.

- а. Хөтөлбөрийн зардал нь үнэн зөв бөгөөд зохих нотолгоотой эсэх;
- б. Банкны дансанд болон жижиг мөнгөн санд буй мөнгө хөрөнгийн удирдлага зохистой эсэх;
- в. Бараа, ажил, үйлчилгээг холбогдох журам зааврын дагуу худалдан авдаг эсэх;
- г. Хөрөнгө, материалын удирдлага зохистой эсэх;
- д. Цагийн бүртгэл, цалин хөлс, урамшууллыг багтаасан хүний нөөцийн зохистой удирдлагатай эсэх;
- е. МСК эсвэл ММСС-аас шууд хөрөнгө бэлтгэх, хөрөнгийг данснаас хасах үйл явц зохистой эсэх;
- ё. Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд материаллаг нөлөөтэй гэрээ, холбогдох хууль тогтоомжийг мөрддөг эсэх. Тухайлбал, Худалдан авах ажиллагааны гэрээ, Худалдан авах ажиллагааны зааварчилгаа, Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөг дагаж мөрдөж буй эсэх.

Гэрээ, холбогдох хууль тогтоомжийн нийцэл

Хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой гэрээний нөхцөл, холбогдох хууль тогтоомжийн нийцлийг тодорхойлох аудитын шаардлагыг хангах үүднээс бид АМНБИ-ийн SAS No. 122 (AU-C sec 935) Нийцлийн аудит стандартыг ашигласан.

Аудитын ажлын даалгаврын зорилгыг хангах, МСК-ын аудитын зааварчилгаа болон Компакт гэрээний нийцэлтэй холбоотой гол асуудлуудыг тодорхойлох, хөтөлбөрийн талаарх ойлголт авахад дараах удирдамж, бусад баримт бичүүдийг нягтлан үзэв.

Гол удирдамж гэрээнүүд:

- Мянган Сорилтын Компакт Гэрээ
- Хөтөлбөр Хэрэгжүүлэх Гэрээ
- Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн гэрээ

Нэмэлт гэрээнүүд:

- ММСС ба Cardno Emerging Markets USA, Ltd хоорондын Санхүүгийн төлөөлөгчийн гэрээ
- ММСС ба Charles Kendall and Partners Ltd хоорондын Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн гэрээ
- ММСС ба Худалдаа Хөгжлийн Банк хоорондын Банкны гэрээ

Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ:

- Ус сувгийн удирдах газар (УСУГ)
- Нийслэлийн газар зохион байгуулалтын алба
- Үндэсний статистикийн газар
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл

МСК-ын зааварчилгаа:

- Буцалтгүй тусламж хүлээн авах орны оруулах хувь хэмжээний тухай зааварчилгаа
- Байгаль орчны зааварчилгаа
- Хөтөлбөрийн зааварчилгаа
- Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа
- Эрх бүхий этгээдээс гэрээлсэн санхүүгийн аудитад баримтлах зааварчилгаа
- Жендерийн бодлого
- Жендерийн асуудлыг төсөл, хөтөлбөрт тусгах зааварчилгаа
- Компакт гэрээний хэрэгжилтэд оролцох Засгийн газрын байгууллагын Зардлын зарчим
- Тайлан гаргах зааварчилгаа
- Хөтөлбөр хаалтын зааварчилгаа
- Хариуцлагатай этгээд болон Хэрэгжилтийн бүтцийн зааварчилгаа
- Мониторинг, үнэлгээний бодлого
- Эдийн засгийн бодлого болон үр өгөөж хүртэгчийн шинжилгээний зааварчилгаа
- Олон улсын барааны тэмдэгтийн стандарт

Компакт гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой ММСС-аас боловсруулсан дараах төлөвлөгөө, тайлан болон бусад баримт бичиг:

- Ажлын төлөвлөгөө
- Санхүүгийн дэлгэрэнгүй төлөвлөгөө
- Аудитын төлөвлөгөө
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө
- Санхүүгийн хариуцлагын түр журам
- Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө
- Худалдан авах ажиллагааны түр журам
- Худалдан авах ажиллагааны журам
- Хэрэгжилтийн төлөвлөгөө
- Нийгэм, жендерийн асуудал тусгах төлөвлөгөө
- Үзүүлэлт хянах хүснэгт
- Хүний нөөцийн гарын авлага
- Санхүүгийн луйвар, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө
- Ёс зүйн дүрэм
- Дотоод аудитын дүрэм
- Дотоод аудитын гарын авлага
- Тендер шалгаруулалтад оролцогчдын санал, гомдол хүлээн авч, шийдвэрлэх журам
- ММСС Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм
- Удирдах Зөвлөлийн тогтоол, хурлын тэмдэглэл
- Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр

2.3 Аудитын хөтөлбөрүүд

Аудитын баг дараах аудитын хөтөлбөрт тусгагдсан горимуудыг хэрэгжүүлсэн.

- Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн аудитын хөтөлбөр
- Дотоод хяналтын аудитын хөтөлбөр
- Нийцлийн аудитын хөтөлбөр
- Худалдан авах ажиллагааны аудитын хөтөлбөр
- Луйвар, хууль бус/эрх мэдлээ хэтрүүлэх үйлдлийн аудитын хөтөлбөр
- Санхүүгийн тайлангийн мэдээллийн системийг үнэлэх аудитын хөтөлбөр
- Бусад аудитад хамрагдах нийлүүлэгчдэд хэрэгжих аудитын хөтөлбөр
- Төлбөрийн нэгдсэн системийн аудитын хөтөлбөр
- Холбоотой талуудын аудитын хөтөлбөр
- Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аудитын хөтөлбөр

2.4 Цар хүрээний хязгаарлалт

Аудитын цар хүрээний хязгаарлалт үүсээгүй.

2.5 ЗГ-ын Аудитын Стандартын үл тохирол

Монгол улсад АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын 4 дүгээр бүлгийн 4.16-р заалтад тусгагдсан тасралтгүй боловсролын хөтөлбөр хэрэгждэггүй ч манай аудиторууд ММНБИ-ийн Тасралтгүй боловсролын хөтөлбөрт шаардсаны дагуу жил тутам 20 цагийн мэргэжлийн сургалтанд хамрагддаг.

АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын 5 дугаар бүлгийн 5.60-д харилцан хамааралгүй аудитын эрх бүхий байгууллагаас хөндлөнгийн чанарын үнэлгээ хийлгэхээр заасан байдаг боловч ММНБИ-ээс ийм хөтөлбөр хэрэгждэггүй. Харин Бейкер Тилли Интернэйшнл олон улсын сүлжээнээс бидний гүйцэтгэсэн аудитад сүлжээний түншлэгч байгууллагын партнер болон менежерүүдийг багтаасан дотоод чанарын хяналтын үнэлгээг гурван жил тутамд хэрэгжүүлдэг учраас бид АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын холбогдох заалт хэрэгжээгүйгээс ноцтой үр дагавар үүсэхгүй гэж үзэв.

3. АУДИТЫН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

3.1 БТТГГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны СХТ, КГУС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны СХТ болон КГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны СХТ-тай холбоотой аудитаар илэрсэн асуудал

Бид аудитын үр дүнд БТТГГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан, КГУС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан болон КГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд аливаа эргэлзээтэй зардал тайлагнаагүй гэж дүгнэв.

3.2 ММСС-ийн Санхүүгийн Тайлагналын Дотоод Хяналтын талаар аудитаар илэрсэн асуудал

ММСС-ийн Санхүүгийн Тайлагналын Дотоод Хяналтыг шалгах явцад илэрсэн асуудлыг дараах хүснэгтэнд харуулсан.

Илэрсэн асуудал	Материаллаг сул тал эсвэл ноцтой дутагдал	Хуудас
Дотоод хяналттай холбоотой		
Гэрээлэгчийн явцын тайланг хянаж хүлээн авсан талаар баримт үйлдээгүй	Ноцтой дутагдал	35
Админ хэлтсээс хийгдсэн гэрээний чанар гүйцэтгэлийг дүгнэж баримтжуулаагүй	Ноцтой дутагдал	36
Мэдээллийн аюулгүй байдлын иж бүрэн бодлого байхгүй	Ноцтой дутагдал	37
Эмзэг байдлыг удирдах албан ёсны хөтөлбөр байхгүй	Ноцтой дутагдал	38
Өөрчлөлтийн удирдлагын процесс байхгүй	Ноцтой дутагдал	39
Нөөц сэргээх тест хийдэггүй	Ноцтой дутагдал	40
Бизнесийн Тасралтгүй Байдал болон Гамшгаас Хамгаалах (BC/DR) Төлөвлөгөө байхгүй	Ноцтой дутагдал	41

3.3 ММСС-ийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн нийцлийн талаар аудитаар илэрсэн асуудал

ММСС-ийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн нийцлийг шалгах явцад илэрсэн асуудлыг дараах хүснэгтэнд харуулсан.

Илэрсэн асуудал	Материаллаг эсвэл материаллаг бус	Хуудас
Гэрээ, холбогдох хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой		
Ажилтнуудыг үл ялгаварлан гадуурхахтай холбоотой заалтад зарим нөхцөлийг тусгаагүй	Материаллаг	42
Хүйсээр ялгаварлан гадуурхаж, ялгаатай зохицуулсан тухай	Материаллаг	43
Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийн хэмжээ нь хуульд нийцэхгүй байгаа	Материаллаг	44
Бэлгийн дарамтын эсрэг журамд “Ажлын байр” –ыг дутуу тодорхойлсон тухай	Материаллаг	45
ММСС–ийн “Гомдол шийдвэрлэх журам” шинэ Хөдөлмөрийн тухай хуульд заасан шаардлагатай нийцэхгүй байгаа тухай	Материаллаг	46
Хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан ердийн ажлын өдрөөс уртасгасан цагаар, нэмэлт хөлсгүйгээр ажиллах заалт нь хуульд нийцээгүй	Материаллаг	47
Хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан үл өрсөлдөх үүргийн хугацаа нь хуульд нийцэхгүй	Материаллаг	48
Хөдөлмөрийн загвар гэрээнд албан тушаал тус бүрийн хөдөлмөрийн нөхцөлийн талаар заалт байхгүй	Материаллаг	49

Хүний нөөцийн гарын авлагад илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг ялгаатай нөхцлөөр олгох тухай заалт тусгагдсан	Материаллаг	50
Хүний нөөцийн гарын авлагад ажилтныг халах тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцлах бичгэн мэдэгдлийн оронд нэг сарын цалин хөлс олгох заалт тусгагдсан	Материаллаг	51

3.4 Аудитын үр дүнгийн талаарх Удирдлагын санал дүгнэлт

Өнгөрсөн таван сарын хугацаанд ММСС-ийн удирдлагын баг хараат бус аудитортой маш үр дүнтэй хамтран ажиллалаа.

Аудитаар илэрсэн асуудлуудад ММСС-ийн удирдлагын зүгээс өгсөн хариу тайлбарууд нь тэдгээр асуудлуудын талаарх бидний үзэл бодол, түүнчлэн аудитын зөвлөмжийг амжилттай хэрэгжүүлж байгааг бүрэн илэрхийлсэн гэж үзэж байна.

ММСС нь аудитын хугацаанд Бейкер Тилли Далайван Аудитын зүгээс өгсөн үр дүнтэй саналд талархаж байна. Цаашид, ММСС нь Бейкер Тилли Далайван Аудит ХХК-тай харилцан үр дүнтэй, хараат бус харилцаагаа үргэлжлүүлэн ажиллах болно.

ММСС-ийн удирдлагын зүгээс манай байгууллагын дүрэм, журам, бодлогын баримт бичгүүд, ажилтнууд хамтдаа үр дүнтэй хяналтын механизм бүрдүүлэн, Компакт гэрээг амжилттай хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.



БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: +976-70005401, 70005402
Факс: +976-70005403
E-mail: info@btdalaivanaudit.mn
Web site: www.btdalaivanaudit.mn

САНХҮҮЖИЛТИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАНГИЙН ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ММСС-ийн Удирдах Зөвлөлд
Монголын Мянганы Сорилтын Сан
Монгол улс, Улаанбаатар хот
UNESCO-ийн гудамж, Сүхбаатар дүүрэг
MPM Complex-ийн 5 дугаар давхар

Санхүүгийн тайланд хийсэн аудитын талаар

Бид энэхүү тайланд харуулсан ММСС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангууд, Нэгтгэсэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн нэмэлт тодруулгад аудит хийж, 2022 оны 9 дүгээр сарын 12-ний өдөр аудитын тайлан гаргав.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь АНУ-д нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу Санхүүжилтийн Хариуцлагын Тайланг үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэг хүлээх ба үүнд Санхүүжилтийн Хариуцлагын Тайланг залилан эсвэл алдаанаас хамаарсан материаллаг хэмжээний алдаагүй, үнэн зөв бэлтгэж толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, сайжруулах үйл явц багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Бид хийсэн аудитдаа үндэслэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд дүгнэлтээ илэрхийлэх үүрэгтэй. Дараах догол мөрөнд дурьдсаныг эс тооцвол бид аудитаа АНУ-ын Нягтлан Бодох Бүртгэлийн Ерөнхий Газраас гаргасан ЗГ-ын Аудитын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Энэ стандартаар Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд материаллаг буруу тайлагнал агуулаагүй талаар үндэслэлтэй баталгаа олж авахын тулд биднийг аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг шаарддаг.

Монгол улсад АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын 4 дүгээр бүлгийн 4.16-р заалтад тусгагдсан тасралтгүй боловсролын хөтөлбөр хэрэгждэггүй ч манай аудиторуд ММНБИ-ийн Тасралтгүй боловсролын хөтөлбөрт шаардсаны дагуу жил тутам 20 цагийн мэргэжлийн сургалтанд хамрагддаг. Бид тасралтгүй боловсролын хөтөлбөрийн шаардлагыг бүрэн хангахыг хичээнэ.

АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын 5 дугаар бүлгийн 5.60-д харилцан хамааралгүй аудитын эрх бүхий байгууллагаас хөндлөнгийн чанарын үнэлгээ хийлгэхээр заасан байдаг боловч ММНБИ-ээс ийм хөтөлбөр хэрэгждэггүй. Харин Бейкер Тилли Интернэйшнл олон улсын сүлжээнээс бидний гүйцэтгэсэн аудитад сүлжээний түншлэгч байгууллагын партнер болон менежерүүдийг багтаасан дотоод чанарын хяналтын үнэлгээг гурван жил тутамд хэрэгжүүлдэг учраас бид АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын холбогдох заалт хэрэгжээгүйгээс ноцтой үр дагавар үүсэхгүй гэж үзсэн.

Бидний хэрэгжүүлсэн аудитын горимд Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн дүн ба тодруулгын талаар аудитын нотолгоог олж авах үйл явц багтсан. Хэрэгжүүлэх аудитын горимыг аудиторын мэргэжлийн шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд залилан эсвэл алдаанаас хамаарсан буруу тайлагнал байх эрсдэлийг үнэлэх үйл явц багтана. Эрсдэлийн үнэлгээ хийж, зохих аудитын горимуудыг тодорхойлохдоо аудитор байгууллагын Санхүүжилтийн Хариуцлагын Тайланг үнэн зөв бэлтгэж толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзан үздэг ч байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын

талаар дүгнэлт өгөхийг зорьдоггүй. Иймд бид дотоод хяналтын талаар дүгнэлт илэрхийлэхгүй. Аудитаар байгууллагын хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, удирдлагын гол чухал нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэлтэй байдал, Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангуудад тусгагдсан хөтөлбөрийн орлого, гарсан ба нөхөн төлсөн зардал, МСК-аас шууд санхүүжүүлж авсан хөрөнгө болон техникийн туслалцааг холбогдох гэрээний нөхцөлд заасны дагуу энэ тайлангийн Тодруулга 1-д харуулсан нягтлан бодох бүртгэлийн суурийг баримтлан тайлагнасан байна.

ЗГ-ын Аудитын стандартад заасан бусад тайлагналын шаардлага

ЗГ-ын Аудитын стандартын дагуу бид ММСС-ийн санхүүгийн тайлагналын дотоод хяналт (СТДХ) болон хууль тогтоомж, нийлүүлэгчийн гэрээ, тусламжийн гэрээний заалтуудын нийцлийн талаарх тайлангаа 2022 оны 9 дүгээр сарын 12-ний өдөр гаргасан. Энэхүү тайлан СТДХ болон нийцлийн хувьд бидний хийсэн горим сорилын хамрах хүрээг харуулах зорилготой бөгөөд горим сорилын үр дүнд ММСС-ийн СТДХ эсвэл нийцлийн үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөхийг зориогүй. Энэ тайлан нь ЗГ-ын Аудитын стандартын дагуу хэрэгжсэн аудитын салшгүй хэсэг болохоос гадна аудитын үр дүнг тусгасан Хараат бус Аудиторын Тайлантай хамт уншиж хэрэглэнэ.

Энэхүү тайлан нь ММСС ба МСК-д зориулсан мэдээлэл боловч МСК-аас олон нийтэд зориулсан мэдээлэл болгон гаргаж болно.

Baker Tilly Dalaiwan Audit LLC

Бэйкер Тилли Далайван Аудит ХХК

2022 оны 9 дүгээр сарын 12

4.1 ММСС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Нэгтгэсэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан (БТТГС, КГУС, КГС)
(Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

	Төсөв	Өмнөх хугацаа	Тайлант хугацаа 2021.04.01- 2022.03.31	2022.03.31- нээрх нийт хуримтлагдсан	Эргэлзээтэй зардал		Тодруул- гын дугаар
					Үл зөвшөөрөгдөх	Үл дэмжигдэх	
Санхүүжилтийн орлого:							
МСК-аас санхүүжилт орлого		25,529,988.56	30,060,645.30	55,590,633.86			2
Нийт орлого		25,529,988.56	30,060,645.30	55,590,633.86			
Гарсан зардал:							
Ус хангамж нэмэгдүүлэх төсөл	309,689,204.95	17,641,620.74	25,369,125.39	43,010,746.13			4
Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах	275,720,451.61	17,350,508.72	22,436,270.26	39,786,778.98			4.1
Хаягдал усыг дахин боловсруулах	13,968,753.34	0.00	2,695,526.94	2,695,526.94			4.2
Усны салбарын тогтвортой байдлыг хангах	20,000,000.00	291,112.02	237,328.19	528,440.21			4.3
Мониторинг ба Үнэлгээ	10,330,000.00	0.00	0.00	0.00			
Мониторинг ба Үнэлгээний зардал	10,330,000.00	0.00	0.00	0.00			
Хөтөлбөрийн удирдлага	33,505,945.05	7,772,772.52	4,584,400.28	12,357,172.80			5
Хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх	20,017,844.11	4,471,339.07	2,872,432.16	7,343,771.23			5.1
Санхүүгийн удирдлага	6,079,525.94	1,897,272.45	745,789.12	2,643,061.57			5.2
Худалдан авах ажиллагааны удирдлага	6,662,575.00	1,404,161.00	870,179.00	2,274,340.00			5.3
Аудит	746,000.00	0.00	96,000.00	96,000.00			5.4
Нийт зардал	353,525,150.00	25,414,393.26	29,953,525.67	55,367,918.93			
Хэмнэлт (зардлаас давсан орлого)/Хэтрэлт		115,595.30	107,119.63	222,714.93			
Санхүүжилтийн эхний үлдэгдэл		0.00	115,595.30	0.00			
Санхүүжилтийн эцсийн үлдэгдэл		115,595.30	222,714.93	222,714.93			6

Зөвшөөрч баталсан:

Үйл ажиллагаа хариуцсан захирал  Д.Хулан

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Санхүүгийн Захирал 

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Бэйкер Тилли Далайван Аудит ХХК

4.2 ММСС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны БТТГС-ийн эх үүсвэрийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан
(Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

	Төсөв	Өмнөх хугацаа	Тайлант хугацаа 2021.04.01- 2021.10.31	2021.10.31- нээрх нийт хуримтлагдсан	Эргэлзээтэй зардал		Тодруул- гын дугаар
					Үл зөвшөөрөгдөх	Үл дэмжигдэх	
Санхүүжилтийн орлого:							
МСК-аас санхүүжилт орлого		2,741,044.77	784,105.23	3,525,150.00			2
Нийт орлого		2,741,044.77	784,105.23	3,525,150.00			
Гарсан зардал:							
Ус хангамж нэмэгдүүлэх төсөл	0.00	0.00	0.00	0.00			
Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах	0.00	0.00	0.00	0.00			
Хаягдал усыг дахин боловсруулах	0.00	0.00	0.00	0.00			
Усны салбарын тогтвортой байдлыг хангах	0.00	0.00	0.00	0.00			
Мониторинг ба Үнэлгээ	0.00	0.00	0.00	0.00			
Мониторинг ба Үнэлгээний зардал	0.00	0.00	0.00	0.00			
Хөтөлбөрийн удирдлага	3,525,150.00¹	2,741,044.77	784,105.23	3,525,150.00			7
Хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх	1,232,722.74	701,277.33	531,445.41	1,232,722.74			7.1
Санхүүгийн удирдлага	1,299,986.26	1,175,870.44	124,115.82	1,299,986.26			7.2
Худалдан авах ажиллагааны удирдлага	992,441.00	863,897.00	128,544.00	992,441.00			7.3
Аудит	0.00	0.00	0.00	0.00			
Нийт зардал	3,525,150.00	2,741,044.77	784,105.23	3,525,150.00			
Хэмнэлт (зардлаас давсан орлого)/Хэтрэлт		0.00	0.00	0.00			
Санхүүжилтийн эхний үлдэгдэл		0.00	0.00	0.00			
Санхүүжилтийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	0.00			6

¹БТТГС-ийн эх үүсвэрийн төсвийн МУЗГ-ын удирдан зарцуулах 3,525,150 ам.доллар нь энэхүү санхүүгийн аудитад хамаарна. БТТГС-ийн эх үүсвэрийн санхүүжилт 2021 оны 10 дугаар сарын 31-нээр бүрэн зарцуулагдаж дууссан.

Зөвшөөрч баталсан:

Үйл ажиллагаа хариуцсан захирал

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Санхүүгийн Захирал

Г.Уранчимэг

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Бэйкер Тилли Далайван Аудит ХХК

Хараат бус аудиторын тайлан – Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл

4.3 ММСС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны КГУС-ийн эх үүсвэрийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан
(Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

	Төсөв	Өмнөх хугацаа	Тайлант хугацаа 2021.04.01-2022.03.31	2022.03.31-нээрх нийт хуримтлагдсан	Эргэлзээтэй зардал		Тодруул-гын дугаар
					Үл зөвшөөрөгдөх	Үл дэмжигдэх	
Санхүүжилтийн орлого:							
МСК-аас санхүүжилт орлого		22,788,943.79	2,970,145.92	25,759,089.71			2
Нийт орлого		22,788,943.79	2,970,145.92	25,759,089.71			
Гарсан зардал:							
Ус хангамж нэмэгдүүлэх төсөл	20,823,590.46	17,641,620.74	1,177,017.60	18,818,638.34			8
Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах	19,984,727.10	17,350,508.72	910,985.48	18,261,494.20			8.1
Хаягдал усыг дахин боловсруулах	29,053.13	0.00	29,053.13	29,053.13			8.2
Усны салбарын тогтвортой байдлыг хангах	809,810.23	291,112.02	236,978.99	528,091.01			8.3
Мониторинг ба Үнэлгээ	0.00	0.00	0.00	0.00			
Мониторинг ба Үнэлгээний зардал	0.00	0.00	0.00	0.00			
Хөтөлбөрийн удирдлага	7,236,409.54	5,031,727.75	1,851,966.25	6,883,694.00			9
Хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх	5,878,743.53	3,770,061.74	1,755,966.25	5,526,027.99			9.1
Санхүүгийн удирдлага	721,402.01	721,402.01	0.00	721,402.01			9.2
Худалдан авах ажиллагааны удирдлага	540,264.00	540,264.00	0.00	540,264.00			9.3
Аудит	96,000.00	0.00	96,000.00	96,000.00			9.4
Нийт зардал	28,060,000.00	22,673,348.49	3,028,983.85	25,702,332.34			
Хэмнэлт (зардлаас давсан орлого)/Хэтрэлт		115,595.30	(58,837.93)	56,757.37			10
Санхүүжилтийн эхний үлдэгдэл		0.00	115,595.30	0.00			
Санхүүжилтийн эцсийн үлдэгдэл		115,595.30	56,757.37	56,757.37			6

Зөвшөөрч баталсан:

Үйл ажиллагаа хариуцсан захирал

Д.Хулан

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Санхүүгийн Захирал

Г.Уранчимэг

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Бэйкер Тилли Далайван Аудит ХХК

4.4 ММСС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны КГС-ийн эх үүсвэрийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан
(Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

	Төсөв	Өмнөх хугацаа	Тайлант хугацаа 2021.04.01- 2022.03.31	2022.03.31- нээрх нийт хуримтлагдсан	Эргэлзээтэй зардал		Тодруул- гын дугаар
					Үл зөвшөөрөгдөх	Үл дэмжигдэх	
Санхүүжилтийн орлого:							
МСК-аас санхүүжилт орлого		0.00	26,306,394.15	26,306,394.15			2
Нийт орлого		0.00	26,306,394.15	26,306,394.15			
Гарсан зардал:							
Ус хангамж нэмэгдүүлэх төсөл	288,865,614.49	0.00	24,192,107.79	24,192,107.79			11
Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах	255,735,724.51	0.00	21,525,284.78	21,525,284.78			11.1
Хаягдал усыг дахин боловсруулах	13,939,700.21	0.00	2,666,473.81	2,666,473.81			11.2
Усны салбарын тогтвортой байдлыг хангах	19,190,189.77	0.00	349.20	349.20			11.3
Мониторинг ба Үнэлгээ	10,330,000.00	0.00	0.00	0.00			
Мониторинг ба Үнэлгээний зардал	10,330,000.00	0.00	0.00	0.00			
Хөтөлбөрийн удирдлага	22,744,385.51	0.00	1,948,328.80	1,948,328.80			12
Хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх	12,906,377.84	0.00	585,020.50	585,020.50			12.1
Санхүүгийн удирдлага	4,058,137.67	0.00	621,673.30	621,673.30			12.2
Худалдан авах ажиллагааны удирдлага	5,129,870.00	0.00	741,635.00	741,635.00			12.3
Аудит	650,000.00	0.00	0.00	0.00			
Нийт зардал	321,940,000.00	0.00	26,140,436.59	26,140,436.59			
Хэмнэлт (зардлаас давсан орлого)/Хэтрэлт		0.00	165,957.56	165,957.56			
Санхүүжилтийн эхний үлдэгдэл		0.00	0.00	0.00			
Санхүүжилтийн эцсийн үлдэгдэл		0.00	165,957.56	165,957.56			6

Зөвшөөрч баталсан:

Үйл ажиллагаа хариуцсан захирал

Д.Хулан

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Санхүүгийн Захирал

Г.Уранчимэг

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 12

Бэйкер Тилли Далайван Аудит ХХК

Хуудас | 22

Нэгтгэсэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн нэмэлт тодруулга

1. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого

ММСС-ийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогыг дараах хэсэгт харуулав.

1.1. Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан болон бусад нэмэлт тайланг бэлтгэсэн үндэслэл

Тайлант хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайланг тохируулсан мөнгөн суурьт үндэслэн бэлтгэдэг. Энэ сууриар орлогыг мөнгөн хөрөнгө хүлээн авсан үед, зардлыг мөнгөн хөрөнгө гарсан үед хүлээн зөвшөөрдөг. Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангаас гадна КГУС болон КГС-ийн эх үүсвэрийн хувьд сар тутам нэмэлт тайланг бэлтгэдэг.

- i. Урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл
- ii. Бэлтгэн нийлүүлэгчид төлөх өр төлбөр эсвэл төлбөрөөс суутгаж үлдээсэн дүн

1.2. Орлого

Орлого нь дараах аргуудаар хүлээн авсан МСК-ын Буцалтгүй тусламжийн санхүүжилтээс бүрдэнэ.

- ММСС-ийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг АНУ-ын Төрийн сангаас бэлтгэн нийлүүлэгчдэд рүү шууд шилжүүлнэ. Төлбөрийг ам.доллар эсвэл бусад валютаар Төлбөрийн нэгдсэн систем ашиглан хийдэг.
- Дотоодын Зөвшөөрөгдсөн данснаас бэлтгэн нийлүүлэгчдэд эсвэл бусад төлбөр хүлээн авагчдад шилжүүлэх зорилготой төлбөрийг Төлбөрийн нэгдсэн системээр дамжуулан дотоодын банкинд байршиж буй Зөвшөөрөгдсөн Дансанд хүлээн авна.

МСК-аас хүлээн авсан санхүүжилтийн хүүгийн орлогыг Худалдаа Хөгжлийн Банкнд КГУС, КГС эх үүсвэр тус бүрт нээсэн Хүүгийн хуримтлал дансдад (ам.долларын хоёр данс, төгрөгийн хоёр данс) хуримтлуулж, улирал тутам хуримтлагдсан хүүг МСК-т шилжүүлдэг.

1.3. Зардал

Зардлыг бодитойгоор гарсан үед нягтлан бодох бүртгэлд зарцуулалтаар хүлээн зөвшөөрдөг.

1.4. Валютын хөрвүүлэлт

МСК-аас ам.доллараар илэрхийлсэн санхүүжилтийн орлогыг Худалдаа Хөгжлийн Банкнд байршиж буй Зөвшөөрөгдсөн данс (ам.долларын)-нд хүлээн авдаг. Ам.доллараас бусад төрлийн валютаар Зөвшөөрөгдсөн дансдын хооронд шилжүүлсэн санхүүжилтийг Худалдаа Хөгжлийн Банкны солилцооны ханшаар дотоодын валют руу хөрвүүлдэг. Ам.доллараас бусад төрлийн валютаар Төлбөрийн нэгдсэн дансаас шууд төлбөр хийхэд Дотоод Бизнесийн Төв (IBC-Interior Business Center)-өөс санхүүжилт шилжүүлэх үеийн бодит солилцооны ханшаар хөрвүүлдэг. Ам.доллараас бусад төрлийн валютаар Зөвшөөрөгдсөн данс (Төгрөгийн)-наас хийх төлбөрийг Монгол банкны өмнөх өдрийн зарласан хаалтын ханшаар дотоодын валют руу хөрвүүлдэг. Төлбөрийн нэгдсэн дансаас ам.доллараас бусад валютаар хийсэн төлбөрийг бүртгэлд шилжүүлэн бичихдээ Төлбөрийн нэгдсэн дансны төлбөрийн бодит хөрвүүлэлтийн ханшийг ашиглана. Санхүүгийн ажил гүйлгээний ханшийн зөрүүний олз, гарзыг тухайн гүйлгээний төсвийн кодын дагуу зардалд хүлээн зөвшөөрнө. Сар тутмын эцэст ам.доллараас бусад валютаарх бэлэн мөнгө болон банкинд байршиж буй мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Монгол банкны тухайн өдрийн хаалтын ханшаар ам.доллар руу шилжүүлж ханшийн зөрүүг нягтлан бодох бүртгэлд хүлээн зөвшөөрдөг. Тайлант жилийн эцэст ам.доллараас бусад валютаарх мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг 2,849.63 төгрөг гэсэн хаалтын ханшаар ам.долларт хөрвүүлж тайлагнасан.

1.5 Худалдан авсан үндсэн хөрөнгө

МСК-ын санхүүжилтээр худалдан авсан үндсэн хөрөнгийг капиталжуулахгүйгээр шууд зардлаар хүлээн зөвшөөрдөг. 500 ам.доллараас дээш үнийн дүнтэй, 12 сараас их ашиглалтын хугацаатай үндсэн хөрөнгийг биет хяналтын зорилгоор “Үндсэн хөрөнгийн бүртгэл”-д бүртгэдэг. Нэгж эсвэл бүлгийн дүнгээр 500 ам.доллараас дээш үнийн дүнтэй, 12 сараас их ашиглалтын хугацаатай барааг үндсэн хөрөнгө гэж ангилан “Үндсэн хөрөнгийн бүртгэл”-д бүртгэдэг.

2. МСК-ын санхүүжилтийн орлого (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

	БТТГГС (2017.05.03- 2021.10.31)	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
ДБТ-өөс АНУ дотор нийлүүлэгчдэд шилжүүлсэн	1,918,810.06	19,516,933.17	8,171,833.44	29,607,576.67
ДБТ-өөс АНУ-аас бусад улс орны нийлүүлэгчдэд шилжүүлсэн (ам.доллар)	1,164,578.42	5,501,873.98	17,948,972.70	24,615,425.10
ДБТ-өөс АНУ-аас бусад улс орны нийлүүлэгчдэд шилжүүлсэн (бусад валют)	441,761.52	740,282.56	185,588.01	1,367,632.09
Нийт	<u>3,525,150.00</u>	<u>25,759,089.71</u>	<u>26,306,394.15</u>	<u>55,590,633.86</u>

3. МСК-ын санхүүжилтийн хүүгийн орлого (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Зөвшөөрөгдсөн данс (ам.доллар) - Хүүгийн орлого	1,107.98	0.00	1,107.98
Зөвшөөрөгдсөн данс (ам.доллар) - МСК руу шилжүүлсэн хүү	(1,107.98)	0.00	(1,107.98)
Нийт	<u>0.00</u>	<u>0.00</u>	<u>0.00</u>

	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Зөвшөөрөгдсөн данс (төгрөг) - Хүүгийн орлого	0.00	0.00	0.00
Зөвшөөрөгдсөн данс (төгрөг) - МСК руу шилжүүлсэн хүү	0.00	0.00	0.00
Нийт	<u>0.00</u>	<u>0.00</u>	<u>0.00</u>

Засгийн газраас хэрэгжүүлэх Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд, арилжааны банкууд харилцах дансанд хүү тооцохыг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс зогсоосон. Тайлант хугацаанд ММСС-ийн Зөвшөөрөгдсөн дансдад хүүгийн орлого тооцогдоогүй.

4. Ус хангамж нэмэгдүүлэх төсөл (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)**4.1 Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах**

	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил	14,557,683.82	0.00	14,557,683.82
Хөтөлбөрийн хяналт, менежментийн үйлчилгээ үзүүлэх, барилга угсралтын ажилд хяналт тавих үйлчилгээ	3,558,864.00	4,960,264.66	8,519,128.66
НШТ хэрэгжүүлэлтийг дэмжих үйлчилгээ, нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн төлбөр	55,032.75	430,743.12	485,775.87
СР2 ТҮХ-ны гишүүний зардал	61,977.25	0.00	61,977.25
СР3 ТҮХ-ны гишүүний зардал	27,840.00	0.00	27,840.00
БХБЯ-ны ажлын хэсгийн талбайн айлчлал	96.38	810.66	907.04

Инженерүүдэд зориулсан талбайн үнэлгээний тоног төхөөрөмж	0.00	4,690.00	4,690.00
Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, хяналт удирдлагын СКАДА системийн барилга угсралтын ажил	0.00	16,120,887.70	16,120,887.70
Био тархалтын шинжээч: СО/МСА-М/ICS/014	0.00	7,888.64	7,888.64
Нийт	<u>18,261,494.20</u>	<u>21,525,284.78</u>	<u>39,786,778.98</u>

4.2. Хаягдал усыг дахин боловсруулах

	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
ТҮХ-ны зардал/Зөвлөх үйлчилгээ	29,053.13	0.00	29,053.13
Хөтөлбөрийн хяналт, менежментийн үйлчилгээ үзүүлэх, барилга угсралтын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ	0.00	2,012,947.69	2,012,947.69
Уулзалтын байр, катеринг үйлчилгээ	0.00	766.12	766.12
Ус дамжуулах шугам хоолой, ДЦС 3 ба 4-ийн модификацийн нарийвчилсан зураг төсөл	0.00	652,760.00	652,760.00
Нийт	<u>29,053.13</u>	<u>2,666,473.81</u>	<u>2,695,526.94</u>

4.3. Усны салбарын тогтвортой байдлыг хангах

	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаанд үзүүлэх техникийн туслалцаа	166,783.25	0.00	166,783.25
СЕГ-ын Хэрэгжүүлэлтийн гэрээний хүрээнд нөхөн төлөх зардал	54,514.95	0.00	54,514.95
СЕГ-ын Хэрэгжүүлэлтийн гэрээний хүрээнд дотоодын зөвлөхийн зардал	14,129.26	0.00	14,129.26
СЕГ-ын Хэрэгжүүлэлтийн гэрээний хүрээнд ММСС-аас шууд төлөх хэрэгжүүлэлтийн зардал	17,734.55	0.00	17,734.55
Тендерийн үнэлгээний бие даасан зөвлөхүүд	12,663.09	0.00	12,663.09
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа-Бие даасан зөвлөхүүд	19,849.68	0.00	19,849.68
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа-Оролцогч талуудын семинар	1,344.93	0.00	1,344.93
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа-Сургалт	6,815.26	0.00	6,815.26
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаанд үзүүлэх техникийн туслалцааны зөвлөх үйлчилгээ	233,496.55	0.00	233,496.55
Катерингийн үйлчилгээ	759.49	0.00	759.49
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэх оролцогч талуудын уулзалт	0.00	349.20	349.20
Нийт	<u>528,091.01</u>	<u>349.20</u>	<u>528,440.21</u>

5. Хөтөлбөрийн удирдлага (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

5.1. Хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх

	БТТГГС (2017.05.03- 2021.10.31)	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Нарийвчилсан зураг төслийн гүйцэтгэгч сонгох ТҮХ-ны зардал	69,693.71	0.00	0.00	69,693.71
Оффисын түрээс	330,091.33	0.00	0.00	330,091.33
Оффисын байрны дотоод зохион байгуулалт, зураг УМС (MIS)-ийн дэд бүтцийн суурилуулалт, холбогдох үйлчилгээний зардал	49,850.32	0.00	0.00	49,850.32
ҮАА-ы ажилтнуудын цалин	53,000.00	0.00	0.00	53,000.00
ММСС-ийн үйл ажиллагааг эхлүүлэх зардал	80,050.92	0.00	0.00	80,050.92
ММСС-ийн тээврийн хэрэгсэл	548,923.58	0.00	0.00	548,923.58
Гүйцэтгэх захиралд захиргааны дэмжлэг үзүүлэх	99,612.88	0.00	0.00	99,612.88
Хүний нөөцийн удирдлага	1,500.00	0.00	0.00	1,500.00
Оффисын менежментийн зардал	0.00	3,310,123.40	0.00	3,310,123.40
Оффисын тоног төхөөрөмж, системийн зардал	0.00	977,531.39	1,491.81	979,023.20
Оффисын хангамж, материалын зардал	0.00	882,318.42	574,655.61	1,456,974.03
Харилцаа холбоо	0.00	90,110.87	471.64	90,582.51
Тээврийн зардал	0.00	96,236.53	0.00	96,236.53
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах зардал	0.00	8,217.15	0.00	8,217.15
Мэргэжлийн үйлчилгээ	0.00	81,420.41	8,401.44	89,821.85
Нийт	1,232,722.74	5,526,027.99	585,020.50	7,343,771.23

5.2. Санхүүгийн удирдлага

	БТТГГС (2017.05.03- 2021.10.31)	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Санхүүгийн төлөөлөгчийн зардал	1,241,158.28	721,402.01	621,673.30	2,584,233.59
Санхүүгийн төлөөлөгчийн зар сурталчилгааны зардал	13,845.16	0.00	0.00	13,845.16
Санхүүгийн төлөөлөгчийн ТҮХ-ны зардал	44,982.82	0.00	0.00	44,982.82
Нийт	1,299,986.26	721,402.01	621,673.30	2,643,061.57

5.3. Худалдан авах ажиллагааны удирдлага

	БТТГГС (2017.05.03- 2021.10.31)	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн зардал	992,441.00	540,264.00	741,635.00	2,274,340.00
Нийт	992,441.00	540,264.00	741,635.00	2,274,340.00

5.4. Аудит

	БТТГГС (2017.05.03- 2021.10.31)	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Аудитын зардал	0.00	96,000.00	0.00	96,000.00
Нийт	0.00	96,000.00	0.00	96,000.00

6. Санхүүжилтийн үлдэгдэл/тохируулга (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

	БТТГГС (2017.05.03- 2021.10.31)	КГУС (2018.07.27- 2022.03.31)	КГС (2021.04.01- 2022.03.31)	Нэгтгэсэн 2022.03.31
Зөвшөөрөгдсөн данс (ам.доллар)	0.00	51,538.21	165,500.55	217,038.76
Дебит картны данс (ам.доллар)	0.00	996.40	0.00	996.40
Зөвшөөрөгдсөн данс (төгрөг)	0.00	2,526.96	425.54	2,952.50
Замд яваа мөнгө (төгрөг)*	0.00	867.26	31.47	898.73
Жижиг мөнгөн сангийн дебит картны данс (төгрөг)	0.00	705.06	0.00	705.06
Шатахууны дебит картны данс (төгрөг)	0.00	123.48	0.00	123.48
Нийт	0.00	56,757.37	165,957.56	222,714.93

*2022 оны 3 дугаар сарын 31-ны өдөр Жижиг мөнгөн сангийн данснаас Зөвшөөрөгдсөн данс (Төгрөгийн) руу шилжүүлсэн КГУС-ийн эх үүсвэрийн US\$ 867.26 (2,557,075.68 төгрөг), КГС-ийн эх үүсвэрийн US\$31.47 (92,000.00 төгрөг)-н үлдэгдлийг замд яваа мөнгөөр тайлагнасан.

7. БТТГГС – Хөтөлбөрийн удирдлага (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

7.1 Хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх

	Өмнөх хугацаа (2017.05.03- 2021.03.31)	Тайлант хугацаа 2021.04.01- 2021.10.31)	Хуримтлагдсан 2021.10.31
Нарийвчилсан зураг төслийн гүйцэтгэгч сонгох ТҮХ-ны зардал	69,693.71	0.00	69,693.71
Оффисын түрээс	330,091.33	0.00	330,091.33
Оффисын байрны дотоод зохион байгуулалт, зураг	48,974.39	875.93	49,850.32
УМС (MIS)-ийн дэд бүтцийн суурилуулалт, холбогдох үйлчилгээний зардал	53,000.00	0.00	53,000.00
ҮАА-ы ажилтнуудын цалин	80,050.92	0.00	80,050.92
ММСС-ийн үйл ажиллагааг эхлүүлэх зардал	18,354.10	530,569.48	548,923.58
ММСС-ийн тээврийн хэрэгсэл	99,612.88	0.00	99,612.88
Гүйцэтгэх захиралд захиргааны дэмжлэг үзүүлэх	1,500.00	0.00	1,500.00
Нийт	701,277.33	531,445.41	1,232,722.74

7.2 Санхүүгийн удирдлага

	Өмнөх хугацаа (2017.05.03- 2021.03.31)	Тайлант хугацаа 2021.04.01- 2021.10.31)	Хуримтлагдсан 2021.10.31
Санхүүгийн төлөөлөгчийн зардал	1,117,042.46	124,115.82	1,241,158.28
Санхүүгийн төлөөлөгчийн зар сурталчилгааны зардал	15,015.16	0.00	13,845.16
Санхүүгийн төлөөлөгчийн ТҮХ-ны зардал	43,812.82	0.00	44,982.82
Нийт	<u>1,175,870.44</u>	<u>124,115.82</u>	<u>1,299,986.26</u>

7.3. Худалдан авах ажиллагааны удирдлага

	Өмнөх хугацаа (2017.05.03- 2021.03.31)	Тайлант хугацаа 2021.04.01- 2021.10.31)	Хуримтлагдсан 2021.10.31
Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн зардал	863,897.00	128,544.00	992,441.00
Нийт	<u>863,897.00</u>	<u>128,544.00</u>	<u>992,441.00</u>

8. КГУС - Ус хангамж нэмэгдүүлэх төсөл (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

8.1 Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах

	Өмнөх хугацаа (2018.07.27- 2021.03.31)	Тайлант хугацаа (2021.04.01- 2022.03.31)	Хуримтлагдсан 2022.03.31
Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил	13,763,773.72	793,910.10	14,557,683.82
Хөтөлбөрийн хяналт, менежментийн үйлчилгээ үзүүлэх, барилга угсралтын ажилд хяналт тавих үйлчилгээ	3,558,864.00	0.00	3,558,864.00
НШТ хэрэгжүүлэлтийг дэмжих үйлчилгээ, нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн төлбөр	0.00	55,032.75	55,032.75
СР2 ТҮХ-ны гишүүний зардал	23,231.00	38,746.25	61,977.25
СР3 ТҮХ-ны гишүүний зардал	4,640.00	23,200.00	27,840.00
БХБЯ-ны ажлын хэсгийн талбайн айлчлал	0.00	96.38	96.38
Нийт	<u>17,350,508.72</u>	<u>910,985.48</u>	<u>18,261,494.20</u>

8.2 Хаягдал усыг дахин боловсруулах

	Өмнөх хугацаа (2018.07.27- 2021.03.31)	Тайлант хугацаа (2021.04.01- 2022.03.31)	Хуримтлагдсан 2022.03.31
ТҮХ-ны зардал/Зөвлөх үйлчилгээ	0.00	29,053.13	29,053.13
Нийт	<u>0.00</u>	<u>29,053.13</u>	<u>29,053.13</u>

8.3 Усны салбарын тогтвортой байдлыг хангах

	Өмнөх хугацаа (2018.07.27- 2021.03.31)	Тайлант хугацаа (2021.04.01- 2022.03.31)	Хуримтлагдсан 2022.03.31
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаанд үзүүлэх техникийн туслалцаа	166,783.25	0.00	166,783.25
СЕГ-ын Хэрэгжүүлэлтийн гэрээний хүрээнд нөхөн төлөх зардал	51,792.00	2,722.95	54,514.95
СЕГ-ын Хэрэгжүүлэлтийн гэрээний хүрээнд дотоодын зөвлөхийн зардал	14,129.26	0.00	14,129.26
СЕГ-ын Хэрэгжүүлэлтийн гэрээний хүрээнд ММСС-аас шууд төлөх хэрэгжүүлэлтийн зардал	17,734.55	0.00	17,734.55
Тендерийн үнэлгээний бие даасан зөвлөхүүд	12,663.09	0.00	12,663.09
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа-Бие даасан зөвлөхүүд	19,849.68	0.00	19,849.68
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа-Оролцогч талуудын семинар	1,344.93	0.00	1,344.93
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа-Сургалт	6,815.26	0.00	6,815.26
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаанд үзүүлэх техникийн туслалцааны зөвлөх үйлчилгээ	0.00	233,496.55	233,496.55
Катерингийн үйлчилгээ	0.00	759.49	759.49
Нийт	<u>291,112.02</u>	<u>236,978.99</u>	<u>528,091.01</u>

9. КГУС – Хөтөлбөрийн удирдлага (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

9.1 Хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх

	Өмнөх хугацаа (2018.07.27- 2021.03.31)	Тайлант хугацаа (2021.04.01- 2022.03.31)	Хуримтлагдсан 2022.03.31
Хүний нөөцийн удирдлага	2,017,342.64	1,292,780.76	3,310,123.40
Оффисын менежментийн зардал	690,971.40	286,559.99	977,531.39
Оффисын тоног төхөөрөмж, системийн зардал	848,476.01	33,842.41	882,318.42
Оффисын хангамж, материалын зардал	25,924.88	64,185.99	90,110.87
Харилцаа холбоо	64,616.65	31,619.88	96,236.53
Тээврийн зардал	2,372.27	5,844.88	8,217.15
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах зардал	40,639.69	40,780.72	81,420.41
Мэргэжлийн үйлчилгээ	79,718.20	351.62	80,069.82
Нийт	<u>3,770,061.74</u>	<u>1,755,966.25</u>	<u>5,526,027.99</u>

9.2 Санхүүгийн удирдлага

	Өмнөх хугацаа (2018.07.27- 2021.03.31)	Тайлант хугацаа (2021.04.01- 2022.03.31)	Хуримтлагдсан 2022.03.31
Санхүүгийн төлөөлөгчийн зардал	721,402.01	0.00	721,402.01
Нийт	<u>721,402.01</u>	<u>0.00</u>	<u>721,402.01</u>

9.3 Худалдан авах ажиллагааны удирдлага

	Өмнөх хугацаа (2018.07.27- 2021.03.31)	Тайлант хугацаа (2021.04.01- 2022.03.31)	Хуримтлагдсан 2022.03.31
Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн зардал	540,264.00	0.00	540,264.00
Нийт	<u>540,264.00</u>	<u>0.00</u>	<u>540,264.00</u>

9.4 Аудит

	Өмнөх хугацаа (2018.07.27- 2021.03.31)	Тайлант хугацаа (2021.04.01- 2022.03.31)	Хуримтлагдсан 2022.03.31
Аудитын зардал	0.00	96,000.00	96,000.00
Нийт	<u>0.00</u>	<u>96,000.00</u>	<u>96,000.00</u>

10. КГУС – Хэмнэлт /(Хэтрэлт) (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

Хугацаа	МСК-аас авсан	Гарсан зардал	Хэтрэлт/(Хэмнэлт)
2021 оны 4 дүгээр сар	144,500.00	112,033.38	32,466.62
2021 оны 5 дугаар сар*	132,946.25	188,521.50	(55,575.25)
2021 оны 6 дугаар сар	1,079,418.37	1,040,039.17	39,379.20
2021 оны 7 дугаар сар*	208,269.95	230,587.08	(22,317.13)
2021 оны 8 дугаар сар	143,400.00	138,118.97	5,281.03
2021 оны 9 дүгээр сар	155,800.00	149,348.70	6,451.30
2021 оны 10 дугаар сар	219,750.00	205,202.44	14,547.56
2021 оны 11 дүгээр сар	215,811.10	173,480.58	42,330.52
2021 оны 12 дугаар сар*	243,875.88	286,976.33	(43,100.45)
2022 оны 1 дүгээр сар *	49,516.24	161,681.33	(112,165.09)
2022 оны 2 дугаар сар	199,263.71	164,691.25	34,572.46
2022 оны 3 дугаар сар *	177,594.42	178,303.12	(708.70)
Нийт	<u>2,970,145.92</u>	<u>3,028,983.85</u>	<u>(58,837.93)</u>

*Тухайн хугацааны зардал хүлээн авсан орлогоосоо давсан нь хугацааны эхэнд Зөвшөөрөгдсөн данс нь санхүүжилтийн үлдэгдэлтэй байсантай холбоотой.

11. КГС – Ус хангамж нэмэгдүүлэх төсөл (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

11.1 Газрын доорх усны эх үүсвэрийг шинээр байгуулах

	Өмнөх хугацаа	Тайлант хугацаа (2021.04.01- 2022.03.31)	Хуримтлагдсан 2022.03.31
Хөтөлбөрийн хяналт, менежментийн үйлчилгээ үзүүлэх, барилга угсралтын ажилд хяналт тавих үйлчилгээ	0.00	4,960,264.66	4,960,264.66
НШТ хэрэгжүүлэлтийг дэмжих үйлчилгээ, нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн төлбөр	0.00	430,743.12	430,743.12
БХБЯ-ны ажлын хэсгийн талбайн айлчлал	0.00	810.66	810.66
Инженерүүдэд зориулсан талбайн үнэлгээний тоног төхөөрөмж	0.00	4,690.00	4,690.00
Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, хяналт удирдлагын СКАДА системийн барилга угсралтын ажил	0.00	16,120,887.70	16,120,887.70
Био тархалтын шинжээч: СО/МСА-М/ICS/014	0.00	7,888.64	7,888.64
Нийт	<u>0.00</u>	<u>21,525,284.78</u>	<u>21,525,284.78</u>

11.2 Хаягдал усыг дахин боловсруулах

	<u>Өмнөх хугацаа</u>	<u>Тайлант хугацаа (2021.04.01-2022.03.31)</u>	<u>Хуримтлагдсан 2022.03.31</u>
Хөтөлбөрийн хяналт, менежментийн үйлчилгээ үзүүлэх, барилга угсралтын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ	0.00	2,012,947.69	2,012,947.69
Уулзалтын байр, катеринг үйлчилгээ	0.00	766.12	766.12
Ус дамжуулах шугам хоолой, ДЦС 3 ба 4-ийн модификацийн нарийвчилсан зураг төсөл	0.00	652,760.00	652,760.00
Нийт	<u>0.00</u>	<u>2,666,473.81</u>	<u>2,666,473.81</u>

11.3 Усны салбарын тогтвортой байдлыг хангах

	<u>Өмнөх хугацаа</u>	<u>Тайлант хугацаа (2021.04.01-2022.03.31)</u>	<u>Хуримтлагдсан 2022.03.31</u>
Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэх оролцогч талуудын уулзалт	0.00	349.20	349.20
Нийт	<u>0.00</u>	<u>349.20</u>	<u>349.20</u>

12. КГС – Хөтөлбөрийн удирдлага (Бүх дүнг ам.доллараар илэрхийлсэн)

12.1 Хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх

	<u>Өмнөх хугацаа</u>	<u>Тайлант хугацаа (2021.04.01-2022.03.31)</u>	<u>Хуримтлагдсан 2022.03.31</u>
Оффисын менежментийн зардал	0.00	1,491.81	1,491.81
Оффисын тоног төхөөрөмж, системийн зардал	0.00	574,655.61	574,655.61
Оффисын хангамж, материалын зардал	0.00	471.64	471.64
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах зардал	0.00	8,401.44	8,401.44
Нийт	<u>0.00</u>	<u>585,020.50</u>	<u>585,020.50</u>

12.2 Санхүүгийн удирдлага

	<u>Өмнөх хугацаа</u>	<u>Тайлант хугацаа (2021.04.01-2022.03.31)</u>	<u>Хуримтлагдсан 2022.03.31</u>
Санхүүгийн төлөөлөгчийн зардал	0.00	621,673.30	621,673.30
Нийт	<u>0.00</u>	<u>621,673.30</u>	<u>621,673.30</u>

12.3 Худалдан авах ажиллагааны удирдлага

	<u>Өмнөх хугацаа</u>	<u>Тайлант хугацаа (2021.04.01-2022.03.31)</u>	<u>Хуримтлагдсан 2022.03.31</u>
Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн зардал	0.00	741,635.00	741,635.00
Нийт	<u>0.00</u>	<u>741,635.00</u>	<u>741,635.00</u>



БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: +976-70005401, 70005402
Факс: +976-70005403
E-mail: info@btdalaivanaudit.mn
Web site: www.btdalaivanaudit.mn

Санхүүгийн Тайлагналын Дотоод Хяналт, Нийцэл болон Бусад Асуудлын талаарх Хараат бус Аудиторын Тайлан

ММСС-ийн Удирдах Зөвлөлд
Монголын Мянганы Сорилтын Сан
Монгол улс, Улаанбаатар хот
UNESCO-ийн гудамж, Сүхбаатар дүүрэг
MPM Complex-ийн 5 дугаар давхар

Дараах догол мөрөнд дурьдсаныг эс тооцвол, бид ММСС-ийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн аудитыг АНУ-ын Нягтлан Бодох Бүртгэлийн Ерөнхий Газраас гаргасан ЗГ-ын Аудитын стандартын санхүүгийн аудитад дагаж мөрдөх стандартууд болон АНУ-д нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн аудитын стандартын дагуу хийж гүйцэтгэж тайлангаа 2022 оны 9 сарын 12-ны өдөр гаргасан.

Монгол улсад АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын 4 дүгээр бүлгийн 4.16-р заалтад тусгагдсан тасралтгүй боловсролын хөтөлбөр хэрэгждэггүй ч манай аудиторууд ММНБИ-ийн Тасралтгүй боловсролын хөтөлбөрт шаардсаны дагуу жил тутам 20 цагийн мэргэжлийн сургалтанд хамрагддаг.

АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын 5 дугаар бүлгийн 5.60-д харилцан хамааралгүй аудитын эрх бүхий байгууллагаас хөндлөнгийн чанарын үнэлгээ хяналтын үнэлгээ хийлгэхээр заасан байдаг боловч ММНБИ-ээс ийм хөтөлбөр хэрэгждэггүй. Харин Бейкер Тилли Интернэйшнл олон улсын сүлжээнээс бидний гүйцэтгэсэн аудитад сүлжээний түншлэгч байгууллагын партнер болон менежерүүдийг багтаасан дотоод чанарын хяналтын үнэлгээг гурван жил тутамд хэрэгжүүлдэг учраас бид АНУ-ын ЗГ-ын Аудитын Стандартын холбогдох заалт хэрэгжээгүйгээс ноцтой үр дагавар үүсэхгүй гэж үзсэн.

Санхүүгийн Тайлагналын Дотоод Хяналт (СТДХ)

Бид санхүүгийн тайлангийн аудитыг төлөвлөж гүйцэтгэх явцад ММСС-ийн СТДХ (дотоод хяналт)-ийг үнэлж санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргахад чиглэсэн аудитын горимыг тодорхойлсон ч ММСС-ийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөхийг зориогүй. Иймд бид дотоод хяналтын талаар дүгнэлт илэрхийлэхгүй.

Дотоод хяналтын дутагдалтай байдал нь дотоод хяналтын зохион байгуулалт эсвэл хэрэгжилтээс шалтгаалан удирдлага эсвэл ажилтнууд ердийн нөхцөлд өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа аливаа буруу тайлагналаас сэргийлэх, эсвэл буруу тайлагналыг илрүүлэх ба залруулах боломжгүй байдал юм. Материаллаг сул тал гэж дотоод хяналтын нэг эсвэл хэд хэдэн дутагдалтай байдлын нийлбэр бөгөөд эдгээрээс шалтгаалан байгууллагын санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналаас сэргийлэх, эсвэл буруу тайлагналыг илрүүлэх ба залруулах боломжгүй байдлыг ойлгоно. Дотоод хяналтын ноцтой дутагдалтай тал нь дотоод хяналтын нэг эсвэл хэд хэдэн дутагдалтай байдлын нийлбэр бөгөөд материаллаг сул талаас бага нөлөөтэй боловч байгууллагын засаглах удирдлага анхаарлаа хандуулбал зохих нөхцөл байдал юм.

Энэхүү хэсгийн эхний догол мөрөнд дурьдсан хязгаарлалтын хүрээнд дотоод хяналтыг авч үзсэнээр бүх материаллаг сул тал эсвэл ноцтой дутагдалтай талыг тодорхойлох боломжгүй учраас аудитаар зарим материаллаг сул тал эсвэл ноцтой дутагдалтай тал илрээгүй байж болно. Ийм хязгаарлалтын хүрээнд хийгдсэн бидний аудитын явцад дотоод хяналтын материаллаг сул тал гэж үзэх асуудал илрээгүй. Бид энэхүү тайлангийн аудитаар илэрсэн асуудлын дэлгэрэнгүй гэсэн хэсэгт дотоод хяналтын ноцтой дутагдалтай тал гэж ангилсан асуудлуудыг харуулсан.

ММСС-ийн дотоод хяналтын үйл ажиллагааны талаар илэрсэн зарим асуудлыг бид 2022 оны 9 дүгээр сарын 12-ны байдлаар тусдаа бэлтгэсэн Удирдлагын захидалдаа тайлагнасан.

Нийцэл ба Бусад Асуудал

ММСС-ийн санхүүгийн тайлан материаллаг буруу тайлагналгүй илэрхийлэгдсэн эсэх талаар зохистой баталгаа олж авах, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд шууд болон материаллаг нөлөө үзүүлэхүйц үл нийцэл байгаа эсэхийг тодорхойлохын тулд холбогдох гэрээ, хууль тогтоомж, нийлүүлэгчийн гэрээ, тусламжийн гэрээний тодорхой заалтуудад аудитын горим сорилыг хэрэгжүүлсэн. Тэдгээр заалтанд нийцсэн эсэх талаар дүгнэлт гаргах нь аудитын зорилго биш учраас бид аливаа дүгнэлт илэрхийлээгүй. Үл нийцэл эсвэл бусад асуудлын хувьд хэрэгжүүлсэн аудитын горимын сорилын үр дүнг ЗГ-ын Аудитын стандартад шаардсаны дагуу энэхүү тайлангийн аудитаар илэрсэн асуудлын дэлгэрэнгүй гэсэн хэсэгт тайлагнасан.

ММСС-ийн нийцлийн талаар илэрсэн зарим материаллаг бус асуудлыг бид 2022 оны 9 дүгээр сарын 12-ны байдлаар тусдаа бэлтгэсэн Удирдлагын захидалдаа тайлагнасан.

Аудитаар илэрсэн асуудалд ММСС-аас өгсөн хариулт

Аудитаар илэрсэн асуудалд ММСС-аас өгсөн хариултыг мөн энэхүү тайлангийн аудитаар илэрсэн асуудлын дэлгэрэнгүй гэсэн хэсэгт тусгасан. ММСС-ийн хариулт нь санхүүгийн тайлангийн аудитын хэрэгжүүлэх горим сорилын хэсэгт хамаарахгүй учраас бид тэдгээр хариултын хувьд дүгнэлт илэрхийлэхгүй.

Тайлангийн зорилго

Энэхүү тайлан дотоод хяналт, нийцлийн хувьд бидний хэрэгжүүлсэн аудитын горим сорилын хамрах хүрээг харуулах зорилготой бөгөөд эдгээрийн үр дүнд байгууллагын дотоод хяналт эсвэл нийцлийн үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөхгүй. Энэ тайлан нь ЗГ-ын Аудитын стандартын дагуу байгууллагын дотоод хяналт, нийцэлтэй холбоотой хэрэгжсэн аудитын салшгүй хэсэг болох учраас өөр бусад зорилгоор ашиглагдахгүй.

Baker Tilly Dalaiwan Audit LLC

Бэйкер Тилли Далайван Аудит ХХК

2022 оны 9 дүгээр сарын 12

5. ЭРГЭЛЗЭЭТЭЙ ЗАРДАЛ, АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ**5.1 Аудитын үр дүнгийн дэлгэрэнгүй**

Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан ба Эргэлзээтэй зардал	
Бид ММСС-ийн 2021 оны 4 дугаар сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Нэгтгэсэн Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд “Хязгаарлалтгүй дүгнэлт” өгсөн. Аудитын үр дүнд БТТГГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан, КГУС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайлан, КГС-ийн эх үүсвэрийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Санхүүжилтийн Хариуцлагын Тайланд аливаа эргэлзээтэй зардал тайлагнаагүй гэж дүгнэв.	
Санхүүгийн Тайлагналын Дотоод Хяналт	
Материаллаг сул тал (ММСС-ийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайланг материаллаг буруу тайлагнахаас сэргийлэх, эсвэл буруу тайлагналыг илрүүлэх боломжгүй нөхцөл байдал)	Байхгүй
Ноцтой дутагдал (материаллаг сул талаас бага нөлөөтэй боловч ММСС-ийн Удирдах Зөвлөлийн анхаарлыг хандуулбал зохих нөхцөл байдал)	7 илэрсэн
Материаллаг бус дутагдал (Удирдлагын захидалд харуулсан)	11 илэрсэн
Нийцэл ба Бусад Асуудал	
Материаллаг үл нийцэл	10 илэрсэн
Материаллаг бус үл нийцэл (Удирдлагын захидалд харуулсан)	3 илэрсэн

5.2 Дотоод хяналттай холбоотой аудитаар илэрсэн асуудал

5.2.1 Гэрээлэгчийн явцын тайланг хянаж хүлээн авсан талаар баримт үйлдээгүй

Төрөл: Ноцтой дутагдал

Нөхцөл байдал

Нийт 9 гэрээг түүвэрлэн Гэрээний удирдлага ба менежментийн гарын авлагын дагуу гэрээний хэрэгжилтийг шалгах тестийг хэрэгжүүлсэн. Аудитад хамаарах хугацаанд Tetra Tech Inc-тай байгуулсан 'Хөтөлбөрийн менежментийн зөвлөх үйлчилгээ (NatSec/Proc/004)'-ний гэрээний хувьд ММСС нь зөвлөхөөс 4 тайланг (3 улирлын тайлангууд болон жилийн эцсийн тайлан) хүлээн авсан. Эдгээр тайлангууд нь цаг хугацааны болон чанар байдлын хувьд гэрээний шаардлагад нийцсэн эсэхийг шалгаж, хүлээн авсан талаар баримтыг гэрээний менежер үйлдэж баримтжуулаагүй.

Шалгуур

ММСС-ийн Гэрээний удирдлага ба менежментийн гарын авлагын 3.3.2-д 'зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан явцын тайлангуудыг хянаж, холбогдох шаардлагад нийцсэн эсэхийг баримт үйлдэж баримтжуулахаар заасан. Мөн ММСС-ийн Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөөний 3.5.3-д гэрээний нөхцлийн дагуу бараа, үйлчилгээг хангалттай түвшинд хүргэсэн эсвэл хүлээн авсаныг баримт үйлдэж баталгаажуулахаар заасан.

Шалтгаан

Гэрээнд зарим ажлын явцын тайланд төлбөр төлөх, заримд нь төлбөр төлөхгүй байхаар заасан. Хүлээн авсан баримтыг зөвхөн төлбөр төлсөн явцын тайланд үйлдээд, төлбөр төлөөгүй явцын тайланд үйлдээгүй.

Нөлөөлөл

Зөвлөх үйлчилгээнд нийлүүлсэн тухайн тайлан болон гүйцэтгэлийг гэрээний менежер зохих шаардлагын дагуу хянаж, хүлээн авсан талаар нотолгоо баримт байхгүй.

Аудитын зөвлөмж

ММСС-ийн Гэрээний удирдлага ба менежментийн гарын авлагад заасны дагуу төлбөрийн хуваарьтай эсэхээс үл хамааран гэрээний нөхцлийн дагуу үйлчилгээг хангалттай түвшинд хүлээн авсан гэдгийг баримт үйлдэж баримтжуулах.

Удирдлагын хариу

ММСС нь аудитын саналыг хүлээн авч, ажлын явцын тайланг хүлээн авсан баримт үйлдэж баримтжуулах эсвэл төлбөр төлөх явцад хамт баримтжуулах арга хэмжээ авна.

5.2.2 Админ хэлтсээс хийгдсэн гэрээний чанар гүйцэтгэлийг дүгнэж баримтжуулаагүй

Төрөл: Ноцтой дутагдал

Нөхцөл байдал

Утас, интернет, оффисын түрээс, машин түрээс, цэвэрлэгээ болон зар байршуулах үйлчилгээний зэрэг гэрээг 12-36 сарын хугацаатай байгуулсан. Гэвч эдгээр гэрээний чанар болон гүйцэтгэлийг дүгнэж баримтжуулаагүй байна.

Шалгуур

Гэрээний удирдлага ба менежментийн гарын авлагын 3-р бүлэгт бараа, ажил, үйлчилгээг чанар байдал болон хугацааны хувьд гэрээний шаардлагад нийцсэн эсэхийг хэлтэс нэгжийн захирал шалгаж хүлээн авахаар заасан.

Шалтгаан

Гэрээг сунгахдаа ялангуяа оффисын түрээсийн гэрээг сунгахдаа жил бүр захиргааны захирал болон оффисын менежер түрээслүүлэгчтэй уулзалт хийж гэрээг дүгнэдэг. Уулзалтын протокол албан ёсоор хөтөлдөггүй цаашид анхаарч заавал протокол хөтлөж баталгаажуулах болно.

Нөлөөлөл

Гэрээний гүйцэтгэлийн чанарыг зохих шаардлагын дагуу хянаж, хүлээн авсан талаар нотолгоо байхгүй.

Аудитын зөвлөмж

Эдгээр төрлийн гэрээнүүд нь гэрээний хугацаа богинотой, гэрээний талууд гэрээг цуцлахаар санал гаргаагүй тохиолдолд нэг жилээр автоматаар сунгагдахаар заасан байдаг. Иймд гэрээг сунгагдахаас өмнө гэрээний гүйцэтгэлийн чанарыг шалган дүгнэж сунгах эсэхийг шийддэг байх.

Удирдлагын хариу

Энэхүү зөвлөмжийг хүлээн авлаа.

5.2.3 Мэдээллийн аюулгүй байдлын иж бүрэн бодлого байхгүй

Төрөл: Ноцтой дутагдал

Нөхцөл байдал

ММСС нь мэдээллийн аюулгүй байдлын иж бүрэн бодлого боловсруулж, гаргаагүй байна. ММСС-ийн 2019 оны 11 сард батлан гаргасан "Мэдээллийн технологи ба аюулгүй байдлын журам"-д оффисын тоног төхөөрөмжийн ашиглалт, компьютерийн хэрэглэгч болон сүлжээний хандалт, дата мэдээллийн нөөц, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх үүрэг хариуцлага, гуравдагч талын хандалт болон дата төвийн хандалт зэргийг журамласан байна. Энэ журамыг 2019 оны 11 сараас хойш шинэчлээгүй. Мөн 2019 онд интернет хэрэглэх журмыг гаргаж баталсан байна.

Шалгуур

Байгууллага мэдээллийн аюулгүй байдлын иж бүрэн бодлого журамтай болсоноор санаатай болон санамсаргүй байдлаар гадаад, дотоод мэдээллийн аюулгүй байдлын халдлагад өртөхөөс хамгаалах мэдээллийн аюулгүй байдлын арга хэмжээг зохих түвшинд хэрэгжүүлэх боломжтой. Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг үр дүнтэй байлгах үүднээс удирдлагын зохих түвшинд баталж, холбогдох ажилтнуудад мэдээлэх шаардлагатай.

Шалтгаан

Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг шинэчлэх ажил эхэлсэн бөгөөд төслийг энэ онд багтаан эцэслэхээр төлөвлөж байна.

Нөлөөлөл

Байгууллагын түвшинд хэрэгжихүйц удирдлагаар батлагдсан Мэдээллийн аюулгүй байдлын бичгэн бодлого журамгүйгээс мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг тууштай хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхой стандарт эсвэл аргачлалын дагуу үнэлэх боломжгүй байна.

Аудитын зөвлөмж

Удирдлага дараах асуудлуудыг багтаасан байгууллагын түвшинд хэрэгжүүлэх мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг гаргахыг зөвлөж байна. Бодлогод тусгагдсан асуудлын хувьд жил тутам хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийх нь зүйтэй.

- Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын тодорхойлолт;
- Хандалтыг хянах бодлого ;
- Нөөцийн бодлого;
- Өөрчлөлтийн удирдлага ба чөлөөлөх бодлого;
- Мэдээллийн системийг олж авах, хөгжүүлэх болон засвар үйлчилгээ хийх бодлого;
- Хүний нөөцийн аюулгүй байдлын бодлого;
- Үйл ажиллагааны удирдлагын бодлого;
- Харилцааны аюулгүй байдлын бодлого ;
- Эрсдэлтэй тохиолдлын удирдах бодлого; болон
- Нийцлийн бодлого

ММСС нь мэдээллийн аюулгүй байдлын иж бүрэн бодлого журмыг гаргахдаа ISO 27001 зэрэг олон улсын жишиг мэдээллийн аюулгүй байдлын хүрээг дагахыг зөвлөж байна.

Удирдлагын хариу

Зөвлөмжийг хүлээн авч байна. Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын шинэчлэл хийгдэж байгаа бөгөөд төслийг энэ онд багтаан дуусгахаар төлөвлөж байна.

5.2.4 Эмзэг байдлыг удирдах албан ёсны хөтөлбөр байхгүй

Төрөл: Ноцтой дутагдал

Нөхцөл байдал

Эмзэг байдлыг удирдах албан ёсны хөтөлбөрт мэдээллийн системийн эмзэг байдалд санаатай халдлага хийн шалгах, нэвтрэлтийн тест хийх, тогтоосон эрсдэл аюулыг бууруулахад чиглэсэн тохиромжтой системийг бий болгож хөгжүүлэх талаар заадаг. Аудитын явцад ММСС нь ийм эмзэг байдлыг удирдах албан ёсны хөтөлбөртэй байгаа гэх нотолгоо олж харсангүй.

Шалгуур

Эмзэг байдлыг удирдах хөтөлбөр нь тодорхойлсон сул талаас байгууллагын мэдээллийн систем болон аппликейшн-ийг хамгаалахад тусладаг. Энэхүү хөтөлбөрт байгууллагын мэдээллийн технологийн орчныг тогтмол үнэлэх, боломжит аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах, стандартыг чангатгах тохирох системийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх талаар ихэвчлэн тусгасан байдаг.

Шалтгаан

Эмзэг байдлыг турших хөтөлбөр байхгүй ба ямар нэгэн туршилтыг хараахан хийгээгүй байна.

Нөлөөлөл

Тогтмол хугацааны эмзэг байдлын шалгалт, нэвтрэлтийн тест зэргийг багтаасан үр дүнтэй эмзэг байдлыг удирдах хөтөлбөргүй байх нь системд эмзэг байдал/сул тал үүсэх, энэ байдлыг цаг хугацаанд нь илрүүлж чадахгүй байх эрсдэлтэй. Үүссэн сул талыг ашиглан мэдлэг бүхий халдагч эмзэг систем/мэдээлэлд зөвшөөрөлгүй хандалт хийх, ингэснээр дата мэдээлэл алдах, мэдээллийн нууцын шаардлага хангагдахгүй байх, байгууллагын үйл ажиллагаа тасалдах зэрэг эрсдэл үүсэх талтай.

Аудитын зөвлөмж

Эмзэг байдлыг удирдах албан ёсны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар удирдлагаас анхаарахыг зөвлөж байна. Энэ хөтөлбөрт эмзэг байдлыг шалгах дотоод, гадаад, хараат бус эмзэг байдлыг үнэлгээ хийгдэх талаар тусгах нь зүйтэй. Эмзэг байдлыг удирдах хөтөлбөрт мөн систем/апликейшн-ы тохируулгыг тогтмол шалгах, стандартыг чангатгах замаар системийг шинэчлэх процесс, процедурыг багтаах хэрэгтэй.

Удирдлагын хариу

Эмзэг байдлыг турших хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх зөвлөмжийг хүлээн авч байна. Мөн байнгын шалгалт болон аудит, худалдан авсан програм хангамжийн эмзэг байдлын тест, хараат бус эмзэг байдлын тест зэргийг аудитын зөвлөмжийн дагуу хийх шаардлагатай. Энэ зөвлөмжийн дагуу МСК-ийн Мэдээллийн технологийн баг болон Iron Vine Security компанитай санал солилцож. 2023 оны 1 дүгээр улиралд багтаан дотоод тестийг хийхээр төлөвлөж байна.

5.2.5 Өөрчлөлтийн удирдлагын процесс байхгүй

Төрөл: Ноцтой дутагдал

Нөхцөл байдал

Байгууллага өөрчлөлтийн удирдлагын процессийг тодорхойлон ашиглаж байгаа илтгэх нотолгоо аудитын явцад ирээгүй. Гэвч аюулгүй байдлын тохиргоо болон шинэчлэх үйл явцад өөрчлөлт орсон байгаа ч энэ талаар баримтжуулаагүй. ММСС нь өөрчлөлтийн удирдлагын процессийг баримтжуулалтдаггүй.

Шалгуур

Өөрчлөлтийн удирдлагын албан ёсны процессийг баталж хэрэгжүүлэх нь удирдлага мэдээллийн технологийн өөрчлөлтэй холбоотой эрсдэлийг зөв зохистой тодорхойлж удирдахад туслана. Энэ процесст системийг олж авах, хөгжүүлэх, техник хангамж, аппликэйшн систем, сүлжээ, харилцаа холбооны програм хамгам, системийн програм хангамжийн засвар үйлчилгээ багтана.

Шалтгаан

Мэдээллийн технологийн багт өөрчлөлтийн удирдлагын үйл явцыг хэрэгжүүлэх заавар, дүрэм хараахан гараагүй байна. Багийн гишүүд өөрсдийн файлдаа бичлэг хийдэг.

Нөлөөлөл

Дурьдсан баримтжуулалт байхгүйгээс системд хийгдсэн өөрчлөлтийг үнэлэх, холбогдох эрсдэл/нөлөөллийг үнэлэх, эрсдэл бууруулах тохирсон хяналтыг хэрэгжүүлсэн эсэхийг тодорхойлох боломжгүй.

Аудитын зөвлөмж

Хамгийн багадаа дараах төрлийн өөрчлөлтийг багтаасан өөрчлөлтийн удирдлагын процесс/аргачлалыг тодорхойлж хэрэгжүүлэхийг удирдлагад зөвлөж байна.

- Системийг олж авах, хөгжүүлэх болон засвар үйлчилгээ хийх;
- Аппликэйшн-д гарсан өөрчлөлтүүд (жиш: аппликэйшн тохиргоо хийх, шинэчлэх, сайжруулах).
- Мэдээллийн технологийн дэд бүтцэд хийгдсэн өөрчлөлт (жиш: сүлжээ/техник хангамжийн тохиргоо, төхөөрөмжийн засвар үйлчилгээ)

Энэ өөрчлөлтийн баримтжуулалтанд өөрчлөлтөнд хамрагдсан хэсгүүд, тест хийсэн процедур, тестийн үр дүн, хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө, хэрэглэгчийн хүлээн авах тест, буцаах төлөвлөгөө зэргийг багтаасан байна. Мөн өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн өмнө олж авсан зөвшөөрлийг багтаана.

Удирдлагын хариу

Зөвлөмжийг хүлээн авч байна.

5.2.6 Нөөц сэргээх тест хийдэггүй

Төрөл: Ноцтой дутагдал

Нөхцөл байдал

ММСС нь Нөөц сэргээх тестийг холбогдох нөөцүүдэд хийгээгүй. Нөөц сэргээх тестийн шаардлагыг тодорхойлоогүй.

Шалгуур

Нэн чухал аппликейш програм, дата өгөгдөл болон процессийг сэргээх нөөц соронзон хальс ашигладаг байгууллагын хувьд нөөц соронзон хальсны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж байх шаардлагатай.

Шалтгаан

Нөөцлөлтийг өдөр, долоо хоног, сараар тогтмол авдаг ба соронзон хальсанд хадгалдаг. Харин нөөцлөлтийг сэргээх туршилт болон процессыг нарийн заагаагүй байна.

Нөлөөлөл

Нөөцийн тест хийхгүйгээр дата өгөгдлийг нөөцлөх нь Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөг (BCP)-г мэдээллийн технологийн дата өгөгдлийг сэргээх талыг үр ашиггүй болгох талтай. Учир нь ийм тестгүйгээр гамшгийн өмнө нөөцийн алдааг илрүүлэх боломжгүй юм.

Аудитын зөвлөмж

ММСС нь нөөцийг дахин сэргээх процедурыг баримтжуулан ашиглах нь зүйтэй.

Удирдлагын хариу

Зөвлөмжийг хүлээн авч байна.

5.2.7 Бизнесийн Тасралтгүй Байдал болон Гамшгаас Хамгаалах (BC/DR) Төлөвлөгөө байхгүй

Төрөл: Ноцтой дутагдал

Нөхцөл байдал

ММСС нь Бизнесийн Тасралтгүй Байдал болон Гамшгаас Хамгаалах (BCP/DRP) Төлөвлөгөөг баримтжуулах явц хийгдэж байгаа ч хараахан дуусаагүй байна.

Шалгуур

Бизнесийн Тасралтгүй Байдлын Төлөвлөгөө (BCP) нь байгууллагын цаашдын үйл ажиллагаанд учирч болох аюулыг тодорхойлох, үүсч болзошгүй нөхцөл байдалд тохирсон гэнэтийн төлөвлөгөө бэлтгэхэд тусладаг. Мөн бизнесийн үйл ажиллагаа доголдсон тохиолдолд байгууллагын үйл ажиллагааг цаг тухайд нь зохион байгуулалттай сэргээхэд туслана. Өөрөөр хэлбэл, Гамшгаас Хамгаалах (DRP) Төлөвлөгөөнд гамшгаас өмнөх технологид хамаарах талуудыг сэргээх процедурыг тусгадаг. Гамшгаас Хамгаалах (DRP) Төлөвлөгөө нь Бизнесийн Тасралтгүй Байдлын Төлөвлөгөө (BCP)-ний нэг хэсэг болно.

Шалтгаан

Бизнесийн Тасралтгүй Байдал болон Гамшгаас Хамгаалах төлөвлөгөөний төслийг боловсруулж дууссан ба энэ ондоо багтаан эцэслэх юм.

Нөлөөлөл

Албан ёсны Гамшгийн үед сэргээн засварлах/Бизнесийн Тасралтгүй Байдлын Төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тестээр шалгах процессгүй байх нь байгууллагын үйл ажиллагааг осол, гамшгийн нөхцөл байдалд цаг тухайд нь, зохион байгуулалттайгаар сэргээж чадахгүй байх эрсдэлтэй.

Аудитын зөвлөмж

ММСС нь иж бүрэн Бизнесийн Тасралтгүй Байдал болон Гамшгаас Хамгаалах (BCP/DRP) Төлөвлөгөөг боловсруулахдаа дараах үндсэн асуудлуудыг багтаах нь зүйтэй.

- Мэдээллийн технологийн систем болон үйлчилгээний эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон байгууллагын үйл ажиллагааг дэмжих хамгийн чухал үйлчилгээ/аппликейшн
- Хамгийн ихдээ хүлээн зөвшөөрөх системийн уналт, дата мэдээллийн алдагдал болон уналтын тухайн цэгүүдийг багтаасан байгууллагад ашиглагдаж байгаа бүх аппликейшн-ийн эрсдэлийн үнэлгээ
- Үйлчилгээний тасалдал, хэвийн байдалд эргэн орохын тулд авах шаардлагатай нарийвчилсан арга хэмжээ/системтэй алхмуудыг тодорхойлсон хувилбарууд
- Тестийн төлөвлөгөө, хуваарь, BC/DR төлөвлөгөөг шинэчлэхэд шаардлагатай цаашид сайжруулах хэсгүүдийг тодорхойлох механизм

Удирдлагын хариу

Бизнесийн Тасралтгүй Байдал болон Гамшгаас Хамгаалах төлөвлөгөөний төслийг боловсруулж дууссан ба 9-р сард Iron Vine Security компанийн инженерүүдийг ирэх үеэр эцэслэнэ.

5.3 Гэрээ, хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой аудитаар илэрсэн асуудал

5.3.1 Ажилтнуудыг үл ялгаварлан гадуурхахтай холбоотой заалтад зарим нөхцөлийг тусгаагүй

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

ММСС –ийн Гарын авлагын Хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэсэгт ажилтан болон ирээдүйн ажилтныг ялгаварлан гадуурхахгүй байхтай холбоотой заалтад (4.1 Тэгш боломж) зарим үндэслэлийг (тухайлбал хэл, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, жирэмсэн болон амаржсан эсэх, гадаад төрх) тусгаагүй байна.

Шалгуур

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно” (§6.1) гэж заасан.

Шалтгаан

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд ялгаварлан гадуурхалттай холбоотой дэлгэрэнгүй заалтыг шинээр оруулсан тул дээрх үл нийцсэн нөхцөл байдал үүссэн байна.

Нөлөөлөл

Тодорхой нэг асуудлыг дотоод журмаар зохицуулахдаа хамаарах бусад асуудлыг дутуу орхигдуулснаар, ажилтантай холбоотой шийдвэр гаргах явцад алдаа гарах, ажилтны эрхийг зөрчиж болзошгүй. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын хөдөлмөрийн хяналтын байцаагч шалгалт хийж, ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид ажлын байрны орчин бүрдсэн эсэхийг хянана.

Аудитын зөвлөмж

ММСС –ийн Гарын авлагын “4.1. Тэгш боломж” хэсэгт ажилтан болон ирээдүйн ажилтныг хэл, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, жирэмсэн болон амаржсан эсэх, болон гадаад төрхөөр нь ялгаварлан гадуурхахгүй байх тухай агуулгыг нэмж тусгахыг зөвлөж байна.

Удирдлагын хариу

ММСС нь Хүний нөөцийн гарын авлагыг шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа ба зөвлөмжийг хүлээн авлаа.

5.3.2 Хүйсээр ялгаварлан гадуурхаж, ялгаатай зохицуулсан тухай

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

ММСС–ийн Хүний нөөцийн гарын авлагад 2022 оны 1 дүгээр сард хүчингүй болсон Хөдөлмөрийн хуулийн (1) “Хүүхэд үрчлэн авсан ажилтан (эмэгтэй, ганц бие эцэг) –д Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу “Жирэмсний болон амаржсаны амралт” –г тухайн хүүхэд жар (60) хоногтой болтол хугацаагаар олгоно”; (2) “Эмэгтэй ажилтан эсхүл ганц бие эцэгт Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу доор заасан өдөр бүр хүүхэд асрах чөлөө олгоно” гэсэн заалтууд тусгагдсан хэвээр байна.

Шалгуур

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.1 дэх хэсэгт “Нярай хүүхэд үрчлэн авсан эцэг, эхийн аль нэг нь хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхдийг нь 60 хоногтой болтол хугацаагаар дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжтэй чөлөө олгоно”; 139 дүгээр зүйлийн 139.1 дэх хэсэгт (2) “Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна” гэж заасан. Харин хүүхэд үрчлэн авсны чөлөө эсхүл гурав хүртэлх насны хүүхдээ асрах чөлөө авах хүсэлтэй эрэгтэй ажилтан заавал ганц бие байна гэж заагаагүй.

Шалтгаан

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу, хүнийг хүйсээр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглосон бөгөөд хүүхэд үрчлэн авсны чөлөө эсхүл гурав хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөг ажилтанд эцэг, эх гэж ялгаварлахгүйгээр олгох талаар шинээр зохицуулсан тул дээрх асуудал үүссэн байна.

Нөлөөлөл

Тодорхой нэг асуудлыг дотоод журмаар зохицуулахдаа, хамаарах бусад асуудлыг дутуу орхигдуулснаар, ажилтантай холбоотой шийдвэр гаргах явцад алдаа гарах, ажилтны эрхийг зөрчиж болзошгүй. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын хөдөлмөрийн хяналтын байцаагч шалгалт хийж, ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид ажлын байрны орчин бүрдсэн эсэхийг хянана.

Аудитын зөвлөмж

Иймд Хүний нөөцийн гарын авлагын “10.4. Жирэмсний болон амаржсаны/Эцгийн/Үрчлэлтийн чөлөө” хэсэгт заасан (1) “Хүүхэд үрчлэн авсан ажилтан (эмэгтэй, ганц бие эцэг) –д Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу “Жирэмсний болон амаржсаны амралт” –г тухайн хүүхэд жар (60) хоногтой болтол хугацаагаар олгоно” болон (2) “Эмэгтэй ажилтан эсхүл ганц бие эцэгт Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу доор заасан өдөр бүр хүүхэд асрах чөлөө олгоно” гэсний “ганц бие эцэг” гэснийг хасаж, зохих агуулгын дагуу засварлахыг зөвлөж байна.

Удирдлагын хариу

ММСС нь Хүний нөөцийн гарын авлагыг шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа ба зөвлөмжийг хүлээн авлаа.

5.3.3 Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийн хэмжээ нь хуульд нийцэхгүй байгаа

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

ММСС–ийн Хүний нөөцийн гарын авлагад “ММСС нь ажлын байр хасагдсаны улмаас гэрээг нь цуцалсан ажилтанд түүний нэг сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэмэлт олговор олгоно” (§11.3, гуравдахь догол мөр) гэж заасан нь хуульд заасан шаардлагатай нийцэхгүй байна.

Шалгуур

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд ажлын байр хасагдсан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд олгох тэтгэмжийн хэмжээг тухайн ажилтны ажилласан /ж.нь ММСС –д/ жилээс хамааран ялгаатай тогтоосон (үүнд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэх нь хамааралгүй байна) (§82.1). Тухайлбал, тухайн аж ахуйн нэгж байгууллагад 6 сар – 2 жил хүртэл ажилласан бол 1 ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх, 2 жил – 5 жил хүртэл ажилласан бол 2 ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж (§82.1.1 - §82.1.4) гэх мэт байдлаар тогтоосон байна.

Шалтгаан

Энэхүү зохицуулалтыг шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд шинээр оруулсан тул дээрх үл нийцсэн нөхцөл байдал үүссэн байна.

Нөлөөлөл

ММСС нь дотоод журамдаа шаардлагатай өөрчлөлтийг оруулаагүйн улмаас ажилтантай холбоотой шийдвэр гаргах явцад алдаа гарах, ажилтны эрхийг зөрчиж, улмаар хөдөлмөрийн эрхийн маргаан үүсч болзошгүй гэж үзэж байна. Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон шинэчилсэн Хөдөлмөрийн хуулийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын хөдөлмөрийн хяналтын байцаагч шалгалт хийж, ажилтны эрх асуудлаар хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүхий л асуудлын биелэлтийг шалгах, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Аудитын зөвлөмж

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1 –д заасныг баримтлан ММСС –ийн Гарын авлагын холбогдох хэсэгт шаардлагатай өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

Удирдлагын хариу

ММСС нь Хүний нөөцийн гарын авлагыг шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа ба зөвлөмжийг хүлээн авлаа.

5.3.4 Бэлгийн дарамтын эсрэг журамд “Ажлын байр” –ыг дутуу тодорхойлсон тухай

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

ММСС–ийн Хүний нөөцийн гарын авлагын 2-р Хавсралтаар баталсан “Бэлгийн дарамтын эсрэг журам” –д “ажлын байран дахь бэлгийн дарамт” гэж тооцоход “ажлын байр” гэдэгт хамаарах нөхцлүүдийг заасан. Эдгээр нөхцлүүдэд шинэ Хөдөлмөрийн тухай хуульд тодорхойлсон зарим нөхцлүүд багтаагүй байна.

Шалгуур

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглохоор заасан бөгөөд энэхүү зорилгоор ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа гэдгийг “ажил үүргээ гүйцэтгэх, албан томилолтоор ажиллах, ажилдаа ирэх очих, ээлж солилцох, ажил хүлээлцэх, сургалтад хамрагдах болон ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ” зэрэг байна гэж тодорхойлсон байна.

Шалтгаан

Өмнөх Хөдөлмөрийн тухай хуулинд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох тухай болон ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг тодорхойлсон зохицуулалт байхгүй байсан тул дээрх зохицуулалтгүй нөхцөл байдал үүссэн байна.

Нөлөөлөл

Ажилтан, ажил олгогч хууль бус үйлдэл гаргах, ажилтантай холбоотой шийдвэр гаргах явцад алдаа гарах, ажилтны эрхийг зөрчиж болзошгүй гэж үзэж байна.

Аудитын зөвлөмж

Иймд Гарын авлагын 2-р Хавсралтаар баталсан “Бэлгийн дарамтын эсрэг журам” –д тодорхойлсон “Ажлын байр” –ны тодорхойлолтод “ажилдаа ирэх очих үед; ажил хүлээлцэх үед” гэсэн нөхцөлийг тус тус нэмж оруулахыг зөвлөж байна.

Удирдлагын хариу

ММСС нь Хүний нөөцийн гарын авлагыг шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа ба зөвлөмжийг хүлээн авлаа.

5.3.5 ММСС –ийн “Гомдол шийдвэрлэх журам” шинэ Хөдөлмөрийн тухай хуульд заасан шаардлагатай нийцэхгүй байгаа тухай

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

ММСС–ийн Хүний нөөцийн гарын авлагын 16-р Хавсралтаар баталсан “Гомдол шийдвэрлэх журам” нь шинэ Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалтад нийцэхгүй байна. Тодруулбал, гомдол гаргах болон шийдвэрлэх хугацаа нь хуульд заасан хугацаанаас богино байна.

Шалгуур

Шинэ Хөдөлмөрийн тухай хуульд Хөдөлмөрийн эрхийн маргааныг зохицуулахтай холбоотой харилцааг шинээр хуульчилсан. Хөдөлмөрийн эрхийн маргаан гэдгийг “хөдөлмөрийн хууль тогтоомж, бүх төрлийн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хэрэгжүүлэх, эсхүл эдгээр хэм хэмжээг тайлбарлахтай холбоотойгоор талуудын хооронд үүссэн саналын зөрүү” гэж тодорхойлсон. Мөн маргааныг шийдвэрлэх хугацааны хувьд, “хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан буюу дуусгавар болгосон, эсхүл өөр ажилд шилжүүлсэн, сэлгэн ажиллуулсан тухай ажил олгогчийн шийдвэр” –тэй холбоотой маргааныг тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, бусад хөдөлмөрийн эрхийн маргаантай асуудлыг 90 хоногийн дотор тус тус шийдвэрлэхээр заасан. Мөн зарим гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэх ёстой байна.

Шалтгаан

Өмнөх Хөдөлмөрийн тухай хуулинд хөдөлмөрийн эрхийн маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчлан зохицуулаагүй байсан тул дээрх үл нийцсэн нөхцөл байдал үүссэн байна.

Нөлөөлөл

Гомдол гаргах, шийдвэрлэх хугацааг хуульд зааснаас богино тогтоож өгсөн нь Ажилтны хөдөлмөрийн эрхийн маргааныг зохих ёсоор шийдвэрлүүлэх эрхийг зөрчиж байна. Улмаар Ажилтан хөдөлмөрийн эрх зүйн маргаан үүсгэж болзошгүй гэж үзэж байна. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын хөдөлмөрийн хяналтын байцаагч шалгалт хийж, ажилтны эрх хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүхий л асуудлын биелэлтийг шалгах, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Аудитын зөвлөмж

Иймд Гарын авлагын 16-р Хавсралтаар баталсан “Гомдол шийдвэрлэх журам” –д заасан гомдол шийдвэрлэх хугацаанд зохих өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

Удирдлагын хариу

ММСС нь Хүний нөөцийн гарын авлагыг шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа ба зөвлөмжийг хүлээн авлаа.

5.3.6 Хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан ердийн ажлын өдрөөс уртасгасан цагаар, нэмэлт хөлсгүйгээр ажиллах заалт нь хуульд нийцээгүй

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

Хөдөлмөрийн гэрээний 3.6 дугаар зүйлд “Ажлын цаг: Ердийн ажлын өдрийн үргэлжлэл нь ажлын найман цаг болон үдийн цайны нэг цаг байна. Ердийн ажлын өдрийн цагийн хуваарийг Хүний нөөцийн гарын авлагын дагуу тооцох бөгөөд ажил хэргийн шалтгаанаар түүнд тухай бүр өөрчлөлт оруулж болно. Зарим тохиолдолд А Хавсралтад заасан чиг үүргийг гүйцэтгэхийн тулд Ажилтан нь ердийн ажлын өдрөөс уртасгасан цагаар, нэмэлт хөлсгүйгээр ажиллах шаардлагатай байж болно” гэж заажээ.

Шалгуур

Хөдөлмөрийн тухай хуулийн 109.1 дүгээр зүйлд “Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулахгүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно” гэж заасны дагуу илүү цаг ажилласан ажилтныг нөхөн амруулах эсхүл дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгох ёстой.

Шалтгаан

Байгууллага нь Хөдөлмөрийн гэрээндээ ажилтныг уртасган цагаар, нэмэлт хөлсгүйгээр ажиллах заалт оруулсны улмаас дээрх үл нийцсэн нөхцөл байдал үүссэн байна.

Нөлөөлөл

Байгууллага нь хөдөлмөрийн гэрээгээ хуульд нийцүүлээгүйн улмаас ажилтантай холбоотой шийдвэр гаргах явцад алдаа гарах, ажилтны эрхийг зөрчиж болзошгүй гэж үзэж байна. Төрийн хяналт шалгалтын тухай болон хөдөлмөрийн хуулийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын хөдөлмөрийн хяналтын байцаагч шалгалт хийж, хөдөлмөрийн нөхцөл, ажилтны эрх, ажлын цаг, цалин хөлс нь хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүхий л асуудлын биелэлтийг шалгах, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Аудитын зөвлөмж

МСС-ийн хөдөлмөрийн гэрээний 3.6 дугаар зүйлд заасан “Ажилтан нь ердийн ажлын өдрөөс уртасгасан цагаар, нэмэлт хөлсгүйгээр ажиллах шаардлагатай байж болно” гэсэн заалтыг хасаж, зохих агуулгын дагуу засварлахыг зөвлөж байна.

Удирдлагын хариу

Аудитын зөвлөмжийг хүлээн авлаа.

5.3.7 Хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан үл өрсөлдөх үүргийн хугацаа нь хуульд нийцэхгүй

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

Хөдөлмөрийн гэрээний 4.5.3 дугаар зүйлд “Гэрээний хугацаа болон Гэрээг хүчингүй болгосноос хойшхи 2 (хоёр) жил, эсхүл Компакт гэрээ дуусгавар болох хүртэлх хугацааны аль богино хугацааны туршид Ажилтан нь Монголын МСС-ийн аливаа бусад ажилтанд ажлаас гарах санал тавих, ажлаас гарахыг ятгах, эсхүл өөр бусдаар дамжуулан ийнхүү ажлаас гарах санал тавих, ятгахыг хориглоно” гэж заажээ.

Шалгуур

Хөдөлмөрийн тухай хуулийн 72.3 дугаар зүйлд “Хөдөлмөрийн гэрээн дэх үл өрсөлдөх нэмэлт нөхцөл, эсхүл дагалдах гэрээний үйлчлэх хугацаа нь ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсноос хойш нэг жилээс илүүгүй байна” гэж заасан бөгөөд үл өрсөлдөх үүрэг нь ажилтны хөдөлмөрийн гэрээ хүчингүй болсноос хойш 1 жилээс илүүгүй байхаар зохицуулжээ.

Шалтгаан

Шинэчилсэн Хөдөлмөрийн хуулиар үл өрсөлдөх үүрэгтэй холбоотой асуудлыг шинээр зохицуулсан тул дээрх асуудал үүссэн байна.

Нөлөөлөл

Байгууллага нь хөдөлмөрийн гэрээгээ хуульд нийцүүлээгүйн улмаас ажилтантай холбоотой шийдвэр гаргах явцад алдаа гарах, ажилтны эрхийг зөрчиж болзошгүй гэж үзэж байна. Төрийн хяналт шалгалтын тухай болон хөдөлмөрийн хуулийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын хөдөлмөрийн хяналтын байцаагч шалгалт хийж, хөдөлмөрийн нөхцөл, ажилтны эрх нь хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүхий л асуудлын биелэлтийг шалгах, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Аудитын зөвлөмж

ММСС-ийн хөдөлмөрийн гэрээний 4.5.3 дугаар зүйлд заасан “Гэрээг хүчингүй болгосноос хойшхи 2 (хоёр) жил” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсноос хойш 1 (нэг) жил” болгож өөрчлөхийг зөвлөж байна.

Удирдлагын хариу

ММСС нь Хүний нөөцийн гарын авлагыг шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа ба зөвлөмжийг хүлээн авлаа.

5.3.8 Хөдөлмөрийн загвар гэрээнд албан тушаал тус бүрийн хөдөлмөрийн нөхцөлийн талаар заалт байхгүй - Давтагдсан

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

Хөдөлмөрийн гэрээнд заавал байх ёстой гол нөхцөл болох "хөдөлмөрийн нөхцөл"-ийн талаар заалт байхгүй байна.

Шалгуур

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21.3-т хөдөлмөрийн гэрээ байгуулах үед мөн хуулийн 21.1-т заасан гол нөхцөлийн аль нэгийг талууд тохироогүй бол хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцохгүй гэж заасан байдаг.

Шалтгаан

ММСС-ийн тайлбар: Хөдөлмөрийн гэрээний загварыг МСК болон ММСС-ийн Удирдах Зөвлөлөөс баталсан.

Нөлөөлөл

Хөдөлмөрийн гэрээний хөдөлмөрийн нөхцөл дутуу байгаа учир ММСС-г ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцохгүй байх үндэслэлтэй бөгөөд уг үйлдлийг Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн (2017) 10.16 дугаар зүйлийн 4.3 дахь хэсгийг зөрчсөн гэж үзнэ. Тодруулбал ажил олгогч ажилтантай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулахгүйгээр ажил, үүрэг гүйцэтгүүлсэн гэж үзэж, ажил олгогч буюу ММСС-аар учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, 1,500,000 төгрөг (ойролцоогоор 526,5 ам.доллар) -өөр торгоно.

Аудитын зөвлөмж

Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.10 болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.4-т зааснаар хөдөлмөрийн нөхцөл гэдэгт хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг ойлгоно. MNS 5080:2001 стандарт – “Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Ажиллах нөхцөл, тэдгээрийн ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ” –ний дагуу, ажлын нөхцөлийг хэвийн ба хэвийн бус гэж ангилдаг. Ажлын нөхцөл болон ангиллыг энэхүү стандартын дагуу үнэлж, тодорхойлно. ММСС-ийн албан тушаал тус бүрийн ажиллах нөхцөлийг үнэлж, тодорхойлсны дараа хөдөлмөрийн гэрээний загварт албан тушаал бүрийн хөдөлмөрийн нөхцөлийн зүйл, заалтыг нэмэх шаардлагатай.

Удирдлагын хариу

ММСС нь аудитын зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулах нь МСК болон ММСС-ийн Удирдах Зөвлөлийн шийдвэрээс хамаарна. Иймд ММСС нь энэ асуудлыг МСК-аас бичгээр зөвшөөрөл авч, ММСС-ийн Удирдах Зөвлөлд батлуулах хүсэлтээ танилцуулах болно.

5.3.9 Хүний нөөцийн гарын авлагад илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг ялгаатай нөхцлөөр олгох тухай заалт тусгагдсан - Давтагдсан

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

Зөвхөн А бүлгийн туслах ажилтан Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагыг үндэслэн сард 40 цагаас илүүгүй ажилласан тохиолдолд нэмэгдэл хөлс авах эрхтэй байна. Илүү цаг гэдэг нь Хүний нөөцийн гарын авлагын 7.3-т заасны дагуу хуваарьт ажлын өдрөөс илүү ажилласан цаг эсхүл хуваарьт ажлын долоо хоног эсхүл албан ёсны амралтын өдрүүдэд ажилласан цагийг хэлнэ.

Шалгуур

Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн Стандарт 2–ын зорилгод ММСС нь шударга байдал, үл ялгаварлан гадуурхалтыг дэмжиж, үндэсний хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг дэмжинэ гэж заасан.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 52, 53 дугаар зүйлд зааснаар, хэрэв илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно. Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг нь 2.0 дахин нэмэгдүүлж олгоно. Илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг хамтын болон хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

Шалтгаан

ММСС-ийн тайлбар: МСК-ын Хүнийн нөөцийн журмын дагуу ММСС-ийн Хүний нөөцийн гарын авлагыг боловсруулж, батлуулсан.

Нөлөөлөл

Хөдөлмөрийн тухай хуулиар хүнийг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал эсвэл байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, албан тушаал, боловсрол, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах, хязгаарлах, эсхүл давуу тал олгохыг хориглодог.

Илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг зөвхөн А бүлгийн туслах ажилтнуудад олгож, ажилчдыг албан тушаал, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж буй нь Хөдөлмөрийн тухай хуулийг зөрчсөн хэрэг болно.

Аудитын зөвлөмж

Хүний нөөцийн гарын авлагад заасны дагуу илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлстэй холбоотой асуудлыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг үндэслэн зохицуулах ёстой. Илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс олгохын оронд нөхөн амруулах нь илүү зохистой байдаг.

Хөдөлмөрийн тухай хууль болон Хүний нөөцийн гарын авлагад нийцүүлэн “Ажилтан илүү цагаар ажилласан бол ийнхүү ажилласан хугацаатай тэнцэх хугацаагаар нөхөн амруулна” гэсэн утгатай илүү цагаар ажиллахтай холбоотой заалтыг хөдөлмөрийн гэрээнд нэмж оруулахыг зөвлөж байна.

Удирдлагын хариу

ММСС нь аудитын зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулах нь МСК болон ММСС-ийн Удирдах Зөвлөлийн шийдвэрээс хамаарна. Иймд ММСС нь энэ асуудлыг МСК-аас бичгээр зөвшөөрөл авч, ММСС-ийн Удирдах Зөвлөлд батлуулах хүсэлтээ танилцуулах болно.

5.3.10 Хүний нөөцийн гарын авлагад ажилтныг халах тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцлах бичгэн мэдэгдлийн оронд нэг сарын цалин хөлс олгох заалт тусгагдсан - Давтагдсан

Төрөл: Материаллаг үл нийцэл

Нөхцөл байдал

Хүний нөөцийн гарын авлагын 11.2 дахь хэсэгт “Хэрэв мэдэгдэл өгөөгүй тохиолдолд ММСС нь тус мэдэгдэх хугацааны оронд нэг (1) сарын цалинтай тэнцэх олговор олгоно” гэж заасан. Дараах тохиолдолд нэг (1) сарын өмнө мэдэгдсэний үндсэн дээр хөдөлмөрийн гэрээг цуцалж болно. ММСС нь мэдэгдэх хугацааны оронд нэг (1) сарын цалин хөлс олгохоор сонгож болох бусад тохиолдол:

- ММСС дахь тухайн ажилтны албан тушаалын орон тоо хасагдсан.

Шалгуур

2006 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 33-р тогтоолын 17-р зүйлд заасны дагуу ажил олгогч буюу ММСС нь албан тушаалын орон тоо цомхтгосон тохиолдолд ажилтанд 30 хоногийн өмнө хөдөлмөрийн гэрээ цуцлах тухайгаа бичгээр мэдэгдэж, ажилтан мэдэгдэл хүлээн авсныг гарын үсэг зуруулж, баталгаажуулах ёстой.

Ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон гэсэн үндэслэлээр хөдөлмөрийн гэрээ цуцлах тохиолдолд дээрхтэй ижил шаардлага тавигдана.

Шалтгаан

ММСС-ийн тайлбар: Хүний нөөцийн журмын 11.3 дугаар хэсэгт орон тооны цомхтголын үед дагаж мөрдөх журмыг тодорхойлсон байдаг. Гэтэл энэ хэсэг нь 11.2 дугаар хэсэгт давхардаж орсон байна.

Нөлөөлөл

Орон тооны цомхотгол хийхдээ ажилтанд хөдөлмөрийн гэрээ цуцлах талаар урьдчилан бичгээр мэдэгдэлгүйгээр хөдөлмөрийн гэрээ цуцлах нь процедурын алдаа болдог. Хэдийгээр ажилтан мэдэгдэх хугацааны оронд нэг сарын цалин авахаар хүлээн зөвшөөрсөн байсан ч ажил олгогчийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Хөдөлмөрийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны практик жишээн дээрээс үзэхэд, дээрхтэй ижил тохиолдолд ажилтан нь ажил олгогчийн эсрэг нэхэмжлэл гаргасан бөгөөд Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авч ажилтныг эргүүлэн ажилд авах, хуулийн маргааны үеийн бүх цалин хөлсийг нөхөн төлөхийг ажил олгогчид даалгасан байна.

Аудитын зөвлөмж

“... мэдэгдэх хугацааны оронд нэг (1) сарын цалинтай тэнцэх олговор олгох” гэсэн бүх хэсгийг устгахыг зөвлөж байна. Энэхүү заалт нь Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 33 дугаар тогтоолын 17 дугаар зүйлтэй нийцэхгүй байгаа тул орон тооны цомхтголын үеийн процедурын алдаа болно.

Удирдлагын хариу

ММСС нь аудитын зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулах нь МСК болон ММСС-ийн Удирдах Зөвлөлийн шийдвэрээс хамаарна. Иймд ММСС нь энэ асуудлыг МСК-аас бичгээр зөвшөөрөл авч, ММСС-ийн Удирдах Зөвлөлд батлуулах хүсэлтээ танилцуулах болно.

6. ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ШАЛГАХ

Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж, хэрэгжилтийн байдлыг харуулав.

Зөвлөмж	Хэрэгжилтийн байдал	Хаагдсан/ давтагдсан
<p>1. Дотоод хяналтын асуудал: ММСС-ийн дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсэгт хамаарах зарим зарчим алдагдсан</p> <p>Хүчтэй дотоод хяналтын тогтолцоо нь байгууллагын “сайн засаглал”-ын нэг хэмжүүр болж байдаг. Иймд, дотоод хяналтын тогтолцоог илүү оновчтой ба системтэй бүрдүүлэхийн тулд Америкийн Засгийн Газрын Хариуцлагын Албанаас гаргасан Дотоод хяналтын стандартад заасан зарчмуудыг хангаж буй эсэхийг удирдлагын зүгээс үнэлж үзэх нь зүйтэй. Бидний аудитаар ажиглагдсан хяналтын орчин, эрсдэлийн үнэлгээ, хяналтын мониторингтой холбоотой асуудлуудад ММСС-ийн удирдлага анхаарлаа хандуулж, сайжруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ гэж найдаж байна.</p>	<p>Бүрэн хэрэгжсэн.</p> <p>ММСС нь 2022 оны 3 дугаар сарын 29-ний байдлаар Дотоод хяналтын системийн үнэлгээг хийсэн. Нэгдсэн үнэлгээг дотоод хяналтыг бүрдүүлж бий болгосон байдал (хяналт бодитоор оршин байгаа эсэх) болон түүний үр дүнтэй байдал (хяналтыг хариуцсан нэгж эсвэл ажилтан тууштай хэрэгжүүлдэг, хяналт хэрэгжсэнээр боломжит эрсдэлээс сэргийлэх, илрүүлэх чадвартай эсэх) гэсэн тусдаа үзүүлэлтээр салгаж үнэлэхийг зөвлөж байна.</p>	<p>Хаагдсан</p>
<p>2. Дотоод хяналтын асуудал: Холбоотой талууд болон холбоотой талын ажил гүйлгээг тодорхойлоогүй, тодруулгыг хийгээгүй</p> <p>ММСС холбоотой талуудыг тодорхойлох, холбоотой талын ажил гүйлгээг нэмэлт тодруулгад тусгах талаар бодлого процедурыг тодорхойлж, Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөөний баримт бичигт тусгах хэрэгтэй. Энэ бодлого процедурын хүрээнд ММСС холбоотой талуудын хоорондын харилцаа, холбоотой талын ажил гүйлгээний дүн, эдгээр ажил гүйлгээний үлдэгдлийг жилийн эцсийн Санхүүжилтийн Хариуцлагын Тайлангийн нэмэлт тодруулгад тусгахаар зохицуулсан байна.</p>	<p>Шаардлагагүй болсон.</p> <p>Сүүлд батлагдсан Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөөнд Холбоотой талын ажил гүйлгээний талаар заалт оруулсан. Тус заалтаар холбоотой талын тодруулгыг Татварын ерөнхий хууль болон ААНОАТ-ын хуулийн хүрээнд шаардсан байдаг учраас ММСС-д хамаарахгүй, мөн татварын зорилгоор Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөөнд холбоотой талын гүйлгээг тодруулах шаардлагагүй гэж тодорхойлсон. Сонирхлын зөрчлын шаардлагыг хангахын тулд ММСС-ийн Сонирхлын зөрчлийн бодлогын дагуу ММСС-ийн бүх ажилтнууд сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл бөглөдөг. Ашиг сонирхлын зөрчлийн хуулийн дагуу удирдлагын түвшний ажилтнууд ашиг сонирхлын талаар тайлагнадаг.</p>	<p>Хаагдсан</p>
<p>3. Дотоод хяналтын асуудал: Санхүүгийн төлөөлөгч нь бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөнд тусгагдсан гамшгаас сэргийлэх төлөвлөгөөний туршилт хийгээгүй</p> <p>Санхүүгийн төлөөлөгч нь гамшгаас сэргийлэх төлөвлөгөөг хамгийн багадаа жилд нэг удаа тестлэн шалгаж, үр дүнг баримтжуулах хэрэгтэй.</p>	<p>Бүрэн хэрэгжсэн.</p> <p>ММСС-ийн Санхүүгийн төлөөлөгч нь 2021 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар Гамшгаас сэргийлэх төлөвлөгөөний дагуу тест хийж, үр дүнг тайлагнасан. Гамшгаас сэргийлэх төлөвлөгөөнд нөхөн сэргээх хугацаа (RTO)-г нэмж оруулж байхыг зөвлөж байна.</p>	<p>Хаагдсан</p>
<p>4. Нийцлийн асуудал: Хөдөлмөрийн загвар гэрээнд албан тушаал тус</p>	<p>Хэсэгчлэн хэрэгжсэн.</p>	<p>Давтагдсан</p>

<p>бүрийн хөдөлмөрийн нөхцөлийн талаар заалт байхгүй</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.10, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.4-т зааснаар хөдөлмөрийн нөхцөл гэдэгт хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг ойлгоно. MNS 5080:2001–“Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ажиллах нөхцөл, тэдгээрийн ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ”–ний дагуу, ажлын нөхцөлийг хэвийн ба хэвийн бус гэж ангилдаг. Ажлын нөхцөл болон ангиллыг стандартын дагуу үнэлж, тодорхойлно. Албан тушаал тус бүрийн ажиллах нөхцөлийг үнэлж, тодорхойлж хөдөлмөрийн гэрээний загварт албан тушаал бүрийн хөдөлмөрийн нөхцөлийн зүйл, заалтыг нэмэх шаардлагатай.</p>	<p>ММСС ажилтантай хийх гэрээнд “ажлын байрны нөхцөл”-ийн заалтыг нэмж оруулаад МСК-д хянуулж, батлуулахаар илгээсэн.</p>	<p>(Аудитаар илэрсэн асуудал 5.3.8, Хуудас 49)</p>
<p>5. Нийцлийн асуудал: Хүний нөөцийн гарын авлагад илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг ялгаатай нөхцлөөр олгох тухай заалт тусгагдсан</p> <p>Хүний нөөцийн гарын авлагад заасны дагуу илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлстэй холбоотой асуудлыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг үндэслэн зохицуулах ёстой. Илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс олгохын оронд нөхөн амруулах нь илүү зохистой байдаг. Хөдөлмөрийн тухай хууль болон Хүний нөөцийн гарын авлагад нийцүүлэн “Ажилтан илүү цагаар ажилласан бол ийнхүү ажилласан хугацаатай тэнцэх хугацаагаар нөхөн амруулна” гэсэн утгатай илүү цагаар ажиллахтай холбоотой заалтыг хөдөлмөрийн гэрээнд нэмж оруулахыг зөвлөж байна.</p>	<p>Хэсэгчлэн хэрэгжсэн.</p> <p>ММСС нь Хүний нөөцийн гарын авлагадаа “илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс” заалтад зохих өөрчлөлтийг оруулаад МСК-д хянуулж, батлуулахаар илгээсэн.</p>	<p>Давтагдсан (Аудитаар илэрсэн асуудал 5.3.9, Хуудас 50)</p>
<p>6. Нийцлийн асуудал: Хүний нөөцийн гарын авлагад ажилтныг халах тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцлах бичгэн мэдэгдлийн оронд нэг сарын цалин хөлс олгох заалт тусгагдсан</p> <p>“.. .. мэдэгдэх хугацааны оронд нэг (1) сарын цалинтай тэнцэх олговор олгох” гэсэн бүх хэсгийг устгахыг зөвлөж байна. Энэхүү заалт нь Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 33 дугаар тогтоолын 17 дугаар зүйлтэй нийцэхгүй байгаа тул орон тооны цомхтголын үеийн процедурын алдаа болно.</p>	<p>Хэсэгчлэн хэрэгжсэн.</p> <p>ММСС нь Хүний нөөцийн гарын авлагад байгаа холбогдох заалтыг хасаж өөрчлөн МСК-д хянуулж, батлуулахаар илгээсэн.</p>	<p>Давтагдсан (Аудитаар илэрсэн асуудал 5.3.10, Хуудас 51)</p>